



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯМ



# ЭКОЛОГИЙН БҮС НУТГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хангай, Хөвсгөлийн экологийн бүс нутагт  
хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь

2017 он

# ЭКОЛОГИЙН БҮС НУТГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## Зохиогчид

Майкл Хайнер, Д.Галбадрах, Н.Батсайхан, Ю.Баяржаргал, Жосеф Кисикер, О.Энхтуяа, О.Биндэръяа, Б.Цогтсайхан, Д.Даш, Д.Зүмбэрэлмаа, Б.Оюунгэрэл, Г.Пүрэвбаатар, М.Мөнхзул.

## Судалгааны зөвлөхүүд

Д.Энхбат, П.Цогтсайхан, Р.Ганхуяг, Г.Эрдэнэбаясгалан, Ё.Онон, Ц.Уранчимэг, М.Отгонтөгс, С.Дашдаваа, Б.Шижирболд, С.Түмэнжаргал, Д.Даш, Б.Оюунгэрэл, Я.Адъяа, Н.Цэвээнмядаг, О.Батхишиг, Д.Зүмбэрэлмаа, Э.Ганболд, Б.Мөнхцог, Л.Амгалан, Г.Цогтжаргал, Г.Даваа, Б.Баяртготох, Х.Тэрбиш, С.Шар, Н.Батсайхан, Ч.Болорчулуун, М.Алтанбагана, Б.Чимэддорж, Б.Бүүвэйбаатар, Ж.Оюумаа.

[Англи хэлнээс орчуулсан](#): О.Биндэръяа

[Монгол орчуулгын редактор](#): Н.Батсайхан, Д.Галбадрах

## Товчилсон үгийн жагсаалт

АМГ - Ашигт малтмалын газар

АНУ - Америкийн Нэгдсэн Улс

БОАЖЯ - Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам

БОНХАЖЯ - Байгаль Орчин, Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын Яам

БОНХЯ - Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яам

БОЯ - Байгаль Орчны Яам

БСТ - Бодлого Судлалын Төв

БЦГ - Байгалийн цогцолборт газар

ГМС - Газарзүйн мэдээллийн систем

ГХГЗГ - Газрын Харилцаа, Геодези, Зурагзүйн Газар

ГЗБГЗГ - Газар Зохион байгуулалт, Геодези, Зурагзүйн Газар

ДБХС / WWF - Дэлхийн Байгаль Хамгаалах Сан

ЕСБХБ - Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк

ОУСК - Олон Улсын Санхүүгийн Корпораци

УИХ - Улсын их хурал

ШУА - Шинжлэх ухааны академи

CITES - Зэрлэг амьтан, ургамлын зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах

Вашингтоны конвенци

CMS - Нүүдлийн зүйлийг хамгаалах олон улсын конвенци

IBA - Шувуудад чухал нутаг

IUCN - Дэлхийн байгаль хамгаалах холбоо

SRTM - Shuttle Radar Topograph Mission

TNC - The Nature Conservancy

UNDP - Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр

USFS - АНУ-н Ойн алба

WRI - World Resource Institute

## Эш татах загвар

© The Nature Conservancy Mongolia Program, M. Heiner et al, 2017, Хангай, Хөвсгөлийн экологийн бүс нутгийн үнэлгээ.

© The Nature Conservancy Mongolia Program, Heiner et al, 2017

## Талархал

Засгийн газрын харьяа байгууллага, яам, аймгуудын төрийн захиргааны байгууллагуудын төлөөлөл, их сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагууд, төрийн бус байгууллагуудын ажилтан, судлаачид энэхүү судалгаанд хамтран оролцсон бөгөөд эдгээр нийт оролцогчдын хамтын бүтээл юм. Үүнд:

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам (БОАЖЯ)

Газрын Харилцаа, Геодези, Зураг зүйн Газар (ГХГЗГ)

Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яам

Зам, Тээврийн Хөгжлийн Яам

Дэ Нэйче Консерванси (TNC)

Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (WWF)

Байгаль, Зэрлэг Амьтдыг Хамгаалах Нийгэмлэг (WCS)

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи (ШУА)-ийн Биологийн хүрээлэнгийн Хөхтний экологийн лаборатори,

Монгол Улсын ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Шувуу судлалын лаборатори

Монгол Улсын ШУА-ийн Ботаникийн хүрээлэн

Монгол Улсын ШУА-ийн Газарзүй, Геоэкологийн хүрээлэн

Монгол Улсын Их Сургууль

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Архангай аймаг: Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар,

Баянхонгор аймаг: Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар,

Булган аймаг: Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар,

Завхан аймаг: Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар,

Өвөрхангай аймаг: Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар.

Хөвсгөл аймаг: Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар тус тус хамтран оролцсон юм.

## АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ .....	6
ХУРААНГУЙ .....	7
Тайланг хэрхэн ашиглах вэ? .....	8
<b>1.0 УДИРТГАЛ .....</b>	<b>10</b>
1.1 Судалгаанд хамруулсан бус нутаг .....	10
1.2 Байгаль хамгааллын төлөвлөлт .....	12
1.3 Урьд хийгдэж байсан бус нутгийн байгаль хамгааллын төлөвлөлт, байгаль хамгааллын тэргүүлэх ач холбогдолтой газруудыг тогтоох чиглэлийн судалгааны ажлуудын тойм .....	13
1.4 Хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь .....	14
1.5 Судалгааны үр дүнг ашиглах нь .....	16
<b>2 АРГА ЗҮЙ БА ҮР ДҮН .....</b>	<b>19</b>
2.1 Тойм .....	19
2.2 Хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлын бурдэл .....	21
2.2.1 Газрын экосистемийн ангилал .....	23
2.2.2 Хамгааллын төлөөлөл зүйл .....	33
2.3 Төлөөлүүлэн хамгаалах зорилт .....	33
2.4 Нөлөөллийн индекс .....	35
2.5 Дүн шинжилгээний бүтэц .....	40
2.6 Хамгаалах шаардлагатай газар нутгийг сонгох .....	41
2.7 Судлаачдын тогтоосон хамгаалах шаардлагатай газар нутаг .....	42
<b>3 ХЭЛЭЛЦҮҮЛЭГ .....</b>	<b>43</b>
3.1 Судалгааны ажлын үр дүнг байгаль орчныг хамгаалах ба нөлөөллийг бууруулах үйл ажиллагаанд ашиглах нь .....	43
3.1.1 Тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээний өргөтгөл ба менежмент .....	43
3.1.2 Уул уурхай, эрчим хүчний хөгжлийн нөлөөллийг бууруулах чиглэл .....	44
3.1.3 Зээлдүүлэгчийн гүйцэтгэлийн стандарт: чухал амьдрах орчин .....	45
3.1.4 Дүйцүүлэн хамгаалах газрыг тогтоох нь .....	46
3.1.5 Газар ашиглалтын төлөвлөлт .....	47
3.1.6 Суурь судалгааны үндэслэл болох нь .....	48
3.2 Бусад зөрчилт асуудлууд .....	48
3.2.1 Хамгаалах шаардлагатай газар нутаг ба тусгай зөвшөөрөл давхцсан газар нутаг .....	48
3.2.2 Зэрлэг амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах саад бэрхшээл .....	49
3.2.3 Голын татам, ус намгархаг газрыг хамгаалах нь .....	49
3.2.4 Хуримтлагдах нөлөөлөл .....	50
3.3 Судалгааны дутагдалтай тал ба сайжруулах тухай зөвлөмж, санал .....	50
3.4 Үйл ажиллагааны дараагийн үе шат .....	53
3.4.1 Хамгаалах шаардлагатай газар нутгийг дахин нягтлах нь .....	54
3.4.2 Чадавхи бэхжүүлэх нь .....	54
<b>4 ДҮГНЭЛТ .....</b>	<b>55</b>

**НОМ ЗҮЙ .....** ..... 56**ХАВСРАЛТ .....** ..... 62

Хавсралт 1а: Экосистемийн ангилал: Төлөөлүүлэн хамгаалах зорилтын хүрээнд хамгаалах шаардлагатай газрын талбайн хэмжээ .....	62
Хавсралт 1б: Экосистемийн ангилал: Төлөөлүүлэн хамгаалах зорилтын хүрээнд хамгаалах шаардлагатай газрын хэмжээ .....	69
Хавсралт 2: Сонгон авсан амьтны зүйлийн амьдрах орчны тархацын зураг .....	71
Хавсралт 3: Судалгааны зөвлөх баг 2015 оны 4-р сараас 11-р сар хүртэл хэд хэдэн удаа уулзалт хийж ГМС-ийн тусламжтайгаар боловсруулсан хамгаалах шаардлагатай газар нутгийг сонгосон байдлыг дүгнэн хэлэлцэв .....	101
Хавсралт 4: Газрын экосистемийн ангилал: экосистемийн хэв шинжийн тодорхойлолт .....	102
Хавсралт 5: Газрын экосистемийн ангилал ба Орон зайн загвар .....	117

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1: Газрын экосистемийн ангилал: Мэдээллийн эх сурвалж, зураглал хийсэн аргачлал .....	26
Хүснэгт 2: Газрын экосистемийн ангилал: Судалгаанд хамрагдсан био-газарзүйн мушкин хүрээнд тохиолдох ялгаатай экосистемийн хэв шинжийн тархац .....	27
Хүснэгт 3: Боломжит амьдрах орчны тархацын загвар боловсруулах зорилгоор сонгосон амьтны зүйлийн жагсаалт .....	31
Хүснэгт 4: Нэлөөллийн индексийн тооцоолол .....	39

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1: Монгол орны ландшафт, экологийн бүс нутаг .....	11
Зураг 2: Судалгаанд хамрагдсан бүс нутаг .....	12
Зураг 3: Зайлшгүй хамгаалах шаардлагатай буюу экологийн хувьд чухал ач холбогдолтой газрыг тогтоох үйл явц .....	14
Зураг 4: Хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлыг сонгох нь .....	23
Зураг 5: Газрын экосистемийн ангилал .....	28
Зураг 6: Газрын гадаргын хэв шинж .....	30
Зураг 7: Зүйл болон амьдрах орчны хамаарлын муруй .....	35
Зураг 8: Нэлөөллийн индексийн хүчин зүйлүүд ба ГМС-ийн мэдээллүүд .....	37
Зураг 9: Нэлөөллийн индекс .....	39
Зураг 10: Хамгаалах шаардлагатай газар нутгийн эхний хувилбар .....	42
Зураг 11: Хамгаалах шаардлагатай газар болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй давхцал үүсч буй газрууд .....	48

**Фото зургууд:** Б.Цогтсайхан, Д.Галбадрах

## ӨМНӨХ ҮГ

Монгол орны байгалийн бүс, бүслүүрийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, ховордсон амьтан, ургамал, түүх, соёлын үнэт өвийг хамруулсан онцгой ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалах, улмаар улсын нийт нутаг дэвсгэрийн 30 хүртэлх хувийг улсын тусгай хамгаалалтад авах зорилт Улсын Их Хурлаас баталсан "Төрөөс экологийн талаар баримтлах бодлого" (1998), "Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр" (1998), "Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал" (2001), "Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтууд" (2008), "Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого" (2008), "Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал" (2008), "Ногоон хөгжлийн бодлого" (2014) зэрэг төрийн бодлогын томоохон баримт бичгүүдэд тусгагдсан байдаг.

Төрийн бодлогын энэхүү зорилтыг хэрэгжүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх, экологийн үнэ цэнэ өндөртэй, хамгаалах шаардлагатай газар нутгийг тогтоохын тулд "Экологийн бүс нутгийн үнэлгээ"-г өнгөрсөн хугацаанд Монгол орны хээр,.govийн экологийн бүс нутгуудад хийж гүйцэтгэсэн бөгөөд түүний үргэлжлэл болох Хангай, Хөвсгөлийн экологийн бүс нутгийн үнэлгээний ажил дуусч, судалгааны үр дүng та бүхэнд өргөн барьж буйд баяртай байна.

Хангай, Хөвсгөлийн экологийн бүс нутаг нь олон зүйлийн ховор, ховордсон амьтан, ургамлын зүйлийн чухал амьдрах орчин болохоос гадна Хөвсгөл, Тэрхийн Цагаан Нуур зэрэг томоохон нуур, Сэлэнгэ, Орхон, Чулуут, Дэлгэр, Эг, Шишхид зэрэг голуудын эх бүхий Монгол орны цэнгэг усны нөөц, ойн сан бүхий газруудыг хамрах тул экологийн өндөр ач холбогдолтой газар нутаг юм. Нөгөө талаар Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батlamжилсан

төрийн тахилгат Отгонтэнгэр, Суврага хайрхан уул, тахилга шүтлэгтэй уулс, овоо, ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэлтэй Орхоны хөндийн соёлын дурсгалт газар, мөн олон тооны чuluун зэвсгийн бууц, хадны зураг, буган хөшөө, хүн чuluу, булш хиргисүүр, эртний хотын турь, хэрэм балгас, гэрэлт хөшөө, бичээс, сүм хийд, суврага бүхий манай улсын соёлын өвийн чухал бүс нутаг болно.

Уул уурхай, түүнийг дагасан дэд бүтэц зэрэг хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөөлөл нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөтэй хавсрان амьтан, ургамлын зүйл, тэдгээрийн амьдрах орчин, цэвэр усны хангамж зэрэг экологийн чухал үйлчилгээг тасалдуулах, экологийн хэвийн үйл ажиллагааг эргэлт буцалтгүй өөрчлөлтөд оруулж болзошгүй байна.

Хангай, Хөвсгөлийн экологийн бүс нутгийн үнэлгээний үр дүнд цаашид энэ бүс нутагт хэрэгжих хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг зохицой төлөвлөх, хэрэгжүүлэхдээ энэ бүс нутгийн байгаль орчин, соёлын өв, бэлчээр, усиг хамгаалах асуудлуудыг адил түвшинд авч үзэх, байгалийн зохицол, тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн үнэт мэдээлэл бүхий орон зайн мэдээллийн сан бурдаж байна.

Та бүхэнд толилуулан буй энэхүү тайлан нь Хангай, Хөвсгөлийн экологийн бүс нутагт хөгжлийг байгаль орчинд нөлөө багатайгаар төлөвлөх, бүс нутгийн биологийн олон янз байдлыг хамгаалах асуудлыг ландшафтын хэмжээнд төлөвлөхөд чухал хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна.

Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайд

Д.Оюунхорол

## ХУРААНГҮЙ

Энэхүү тайланд Хангай, Хөвсгөлийн экологийн бүс нутагт хамгаалах шаардлагатай газар нутгийг хэрхэн тогтоосон тухай тусгасан болно. Бид дүн шинжилгээ хийх зорилгоор одоо байгаа мэдээлэл, эрдэм шинжилгээний бүтээлүүд, судлаач шинжээчдийн мэдлэгийг нэгтгэн, экологийн хувьд чухал, хамгаалах шаардлагатай газар нутгийг илрүүлэн тодорхойлох замаар амьдрах орчныг хамгаалах, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр шийдвэр гаргахад дэмжлэг болохуйц мэдээллийн системийг бүрдүүлэв.

1. Хангай, Хөвсгөлийн экологийн бүс нутаг нь Монгол орны төв болон умард хэсэгт хамаарах бөгөөд улсын дэвсгэр нутгийн 22% буюу нийт 350,000 ам километер талбайг эзлэн оршдог. Энэ бүс нутагт үндэсний болон дэлхийн улаан дансанд ховордлын ангилалд бүртгэлтэй устаж болзошгүй, ховордож байгаа болон эмзэг 17 зүйл хөхтөн, шувуу болон хоёр нутагтан амьтан идээшэн амьдардаг юм. Гэвч, уул уурхай, түүнийг дагасан дэд бүтэц зэрэг хөгжлийн үйл ажиллагаа нь зэрлэг амьтан, ургамал ба уламжлалт бэлчээрийн мал аж ахуйд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
2. Бид судалгааны ажлын хүрээнд Хангай, Хөвсгөлийн экологийн бүс нутгийн экологийн үйл явц ба биологийн олон янз байдлын төлөөллийг зохистой хамгаалах, менежментийн арга хэмжээг хэрэгжүүлж болохуйц уудам амьдрах орчныг хамгаалах шаардлагатай газрыг тодорхойлов. Байгаль хамгааллын хувьд чухал ач холбогдолтой эдгээр газар нутгийн сүлжээг бид “хамгаалах шаардлагатай газар нутаг” гэж томъёолсон юм. Судалгааны баг энэхүү өргөн уудам нутгийн онцлог,

биологийн олон янз байдлын болон бусад мэдээллийн олдоц зэргийг харгалзсан арга зүйг боловсруулан ашигласан. Хамгаалах амьтны зүйлийн биологийн олон янз байдал нь газрын зурагт буулгасан экологийн ангилал ба дэлхийн болон Монгол улсын улаан дансны ховордлын зэрэг өндөртэй, судалгааны зөвлөх багийн сонгосон шувуу, хөхтөн, мөлхөгчдийн төлөөлөл болох 29 зүйлээс бүрдэнэ. Бид хамгаалах шаардлагатай газар нутгийг илрүүлэн тогтоохын тулд, эхлээд ялгаатай экосистемийн хэв шинж тус бүрийн тархац, тоо хэмжээ төлөөллийг хангах зорилгыг биелүүлэх, удаад нь хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хүримтлагдах нөлөөлөл болон нөлөөллийн индекс утга дээр тулгуурлан, экологийн нөхцөл байдлын хувьд хамгийн зохистой хувилбарыг сонгох шаардлагуудыг харгалзан үзлээ.

3. Хамгаалах шаардлагатай газар нутагт дараах газрууд хамаарна. Үүнд: а) Улсын тусгай хамгаалалтай газар нутаг, б) бусад үнэлгээгээр илрүүлэн тодорхойлсон байгаль хамгааллын чухал ач холбогдолтой газрууд, в) Экологийн нөхцөл байдал, экосистемийн төлөөллийг хамгийн зохистой хувилбараар сонгох зорилгоор байгаль хамгааллын төлөвлөлт хийхэд ашигладаг “МАРКСАН” програмыг ашиглан сонгосон газар нутгийг тус тус дурдаж болно. Хамгаалах шаардлагатай газар нутагт судалгаанд хамрагдсан бүс нутгийн талбайн 42 хувь буюу 148,000 ам километр дэвсгэр нутагтай нийт 90 нэгж газар хамрагдлаа. Хамгаалах шаардлагатай газар нутгийн 38 хувийг одоогийн улсын тусгай хамгаалалттай 29 газар бүхэлдээ эсхүл хэсэгчлэн эзлэх ажээ.

## Тайланг хэрхэн ашиглах вэ?

Хөгжлийн нөлөөллийг бууруулах уламжлалт хандлага нь нэлээд дутагдалтай. Дэлхийн олон газарт төслийн нөлөөллийг зөвхөн тухайн төслийн нөлөөлөлд өртсөн газар нутгийн хэмжээнд үнэлэх, нөлөөлөлд өртсөн газарт эсхүл түүний ойр зэргэлдээ орших газар бууруулах хэлбэрээр үйл ажиллагаа хэрэгжүүлж байна. Эдгээр нөлөөллийг бууруулах уламжлалт арга барил нь зэрлэг амьтдын чухал амьдрах орчин орон зайн хувьд хумигдахаас сэргийлэх, амьдрах орчин хоорондын холбоос нутаг, экологийн чухал үйл явц бүхий газар нутгийг тэтгэх чиглэлд төдийлэн сайн анхаардаггүй байв. Улмаар, нөлөөллийг бууруулах уламжлалт хандлага нь ирээдүйд нүүрлэх хүндрэл бэрхшээл, хуримтлагдах нөлөөллийг харгалzan үздэггүй сүл талтай.

Судалгааны ажлын үндсэн зорилго нь цаашид хамгаалах шаардлагатай газар нутгийг оновчтой тодорхойлох, байгаль хамгаалах үйл ажиллагааны урт хугацааны үр дүнг хангах талаар санал зөвлөмж дэвшүүлэхэд чиглэгдэв. Энэ дүн шинжилгээ нь ирээдүйн хөгжлийн төсөл, хөтөлбөр болон уур амьсгалын өөрчлөлт (усны нөөц ба чанар, цөлжилт, нийгмийн асуудал зэрэг)-ийн нөлөөллийн улмаас Хангай, Хөвсгөлийн бүс нутагт учирч болохуйц байгаль орчны бүх асуудлыг шүүн хэлэлцэхэд чиглэгдээгүй болно. Эдгээр асуудлын заримыг нь тухайн төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх үед тодорхой авч үзэж болох юм. Харин, дүн шинжилгээ нь аливаа хөгжлийн төсөл, хөтөлбөрийг байгаль хамгаалах асуудалтай хэрхэн тэнцвэртэй уялдуулах, тэдгээрээс байгаль хамгаалалд хувь нэмэр оруулах боломжийн талаар зөвлөмжийг агуулсан. Уг судалгааны ажлын хүрээнд бүрдүүлсэн Газарзүйн Мэдээллийн Систем (ГМС)-ийн мэдээллийг хэрхэн ашиглаж болох тухай зөвлөмжийг дор дурдсан жагсаалтнаас үзнэ үү. Үүнд:

- Монгол улсын газар нутгийн 30 хүртэл хувийг тусгай хамгаалалтад авах тухай Монгол улсын Засгийн газрын зорилтыг биелүүлэх зорилгоор цаашид газар нутгийг тусгай хамгаалалтад хамруулах зөвлөмж, гарын авлага болгох (2.8 болон 3.1.1 хэсгүүдийг харна уу).
- Өнгөрсөн, одоо, ирээдүйд хүний үйл ажиллагаанаас (тухайлбал, хуримтлагдах нөлөөлөл) байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг авч үзэхэд шаардлагатай мэдээлэл, зөвлөмж боловсруулах,
- Хөгжлийн төслийг биологийн олон янз байдлын хамгаалалд чухал ач холбогдолтой газар, усны экосистемээс аль болох алс хэрэгжүүлэх замаар хөгжлийн хөтөлбөр – байгаль хамгааллын хооронд үүсч болзошгүй зөрчлийг бууруулах,
- Хөгжлийн төсөл хэрэгжиж буй газар нутагт нөлөөллийг бууруулах үр ашигтай, цогц арга хэмжээг хэрэгжүүлэх. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ засгийн газрын бодлого, хөгжлийн төлөвлөлттэй уялдуулах, бус нутгийн байгаль хамгаалах зорилтод нийцүүлэх, экологийн хувьд үзүүлсэн нөлөөтэй дүйцэхүйц байх зарчмыг хангах (3.1.4 хэсгийг үзнэ үү),
- Биологийн олон янз байдлын хувьд зэрэг үр дүнд хүргэхүйц байгаль хамгааллын зохистой арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хөгжлийн хөтөлбөрөөс үзүүлэх нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах,
- Аймаг, сумын газар ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах,
- Цаашид хийгдэх биологийн судалгаанд ашиглаж болох амьдрах орчны газрын зураг, суурь мэдээллийг бүрдүүлэх зэрэг ач холбогдлыг дурдаж болно.

Байгаль хамгааллын үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлэхийн тулд амьдрах орчны тархац, учирч болох аюул болон болзошгүй сөрөг нөлөөллийг бус нутгийн болон ландшафтын түвшинд авч үзэж, байгаль хамгаллын тэргүүлэх ач холбогдлыг системтэй тодорхойлох нь чухал. Бид энэ судалгааны ажлаар богино цаг хугацаанд, мэдээлэл хомс нөхцөлд ландшафтын түвшинд байгаль хамгаалах төлөвлөгөө болон шийдвэр гаргах үйл явцыг дэмжих суурь мэдээллийг боловсруулах боломжтойг харуулахыг зорьсон билээ. Энэ судалгааны ажлын

үр дүн ба мэдээлэл нь цаашид нэмэлт мэдээлэл цуглуулах, байнгын мониторинг хийх, шүүн тунгаах, шинэчлэх ажлын эхний алхам гэж ойлгох хэрэгтэй. Бидний сонгон ашигласан болон боловсруулсан дүн шинжилгээний арга зүй нь ил тод, нээлттэй, давтан хэрэглэх боломжтой тул цаашид хянан нягтлах, баталгаажуулах, шүүн тунгаах, сайжруулан шинэчлэхэд хялбараас гадна, судалгааны ажлын бүх үр дүн ба ихэнх мэдээлэл нь нийтэд хүртээмжтэй, байгууллага, судлаачид ашиглах боломжтой байх юм.



# 1.0 УДИРТГАЛ

## 1.1. СУДАЛГААНЫ БҮС НУТАГ

Энэ үнэлгээ хийсэн судалгааны бүс нутгийг Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газраас гүйцэтгэсэн “Биологийн олон янз байдлын орхигдлын үнэлгээ”-ээр ангилж ялгахдаа (Dash, 2007; Chimed-Ochir et al., 2010) Монгол орны төв болон умард хэсэгт орших Хангай, Хөвсгөлийн экологийн бүсэд хамааруулжээ. Тус бүс нутаг нь Монгол орны нийт газар нутгийн 22 хувь буюу 354,000 ам километр талбайг зэлэх бөгөөд судлаач Д.Дашийн тодорхойлсноор (2007) Хөвсгөлийн болон Хангайн бүс хэмээх 2 дэд бүсэд хуваагдана. Энэ бүс нутаг нь эх газрын эрс уур амьсгалын нөхцөлтэй. Сэлэнгэ мөрөн, Орхон голын хөндийд д.т.д. 650 м, харин Хангайн нурууны оргил Отгонтэнгэр д.т.д 4031 м хүртэл өргөгдсөн байдаг. Жилийн дундаж хур тунадас Хангайн уулсын өмнөд хаяа уулс орчим 150 мм-с бага, харин таг цармын бүслүүрт 400 мм-ээс ахиу тунадас унадаг (Hijmans et al., 2005). Хур тунадасны дийлэнхи хэсэг зүн ургамал ургалтын үед унах ба жил бүр хур тунадасны хэмжээ харилцан адилгүй ялгаатай байдаг (von Werden et al., 2010).

Хангай, Хөвсгөлийн судалгааны бүс нутаг нь Улсын тусгай хамгаалалтай 29 газар нутгийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн, мөн Шувуудад чухал 20 газар (IBA)-ыг тус тус дамнан оршдог (Нямбаяр, Цэвээнмядаг, 2009) төдийгүй Архангай аймгийн Тэрхийн Цагаан Нуур нь олон улсын ус намгархаг газрыг хамгаалах RAMSAR-ийн конвенцид бүртгэлтэй газрын нэг юм (RAMSAR, 2011). Мөн Архангай аймгийн нутагт орших Орхоны Хөндий нь Дэлхийн Соёлын Өвийн газарт бүртгэлтэй (UNESCO, 2011b) ажээ.

Тус бүс нутаг нь үндэсний болон дэлхийн дайд устаж болзошгүй, ховордож байгаа болон эмзэг зүйлийн жагсаалтад бүртгэгдсэн 8 зүйл хөхтөн (Clark et al., 2006), 2 зүйл хоёр нутагтан (Тэрбиш нар., 2006), 7 зүйл шувуу (Gombobaatar et al., 2011) нийт 17 угуул зүйл амьтны идээшил нутаг юм. Бүс нутгийн ховордлын эрсдэлтэй зүйлийн жагсаалтад бүртгэгдсэн зүйлээс дурдвал ирвэс (*Uncia uncia*), халиун буга (*Cervus elaphus*), хандгай (*Alces alces*), хүдэр (*Moschus moschiferus*) ба аргаль (*Ovis ammon*)


зэрэг ховордсон зүйл хамаарна. Улаан жагсаалтад бүртгэлтэй шувуудад цагаан тогоруу (*Grus leucogeranus*), хошуу галуу (*Anser cygnoides*), усны нэмрөг бүргэд (*Haliaeetus leucoryphus*) болон хонин тоодог (*Otis tarda*) зэрэг зүйлүүд багтана. Эдгээр устаж буй, ховордсон амьтдын зүйлүүдийн ихэнх зүйлийн тоо толгойн төлөв байдал ба экологийн талаарх мэдээлэл тун хомс, тодорхойгүй байна. Иймд энэ бус нутгийн зэрлэг амьтны суурь судалгааны ажлыг нэн даруй гүйцэтгэх нь зүйтэй (Batsaikhan et al., 2010; Clark et. al 2006).

Монгол улсын хүн амын суурьшил, нягтшил түүхэн үеэс эдүгээ хүртэл сийрэг хэвээр байна (ШУА 2009). Гэвч, 1990 оны зах зээлийн эдийн засгийн шилжилтээс улбаалан энэ бус нутгийн хуурай хээрийн экосистемд үзүүлэх хүний үйл ажиллагааны нөлөө маш эрчимтэй өсөж байна. Мал маллагааны уламжлалт арга хэлбэр, сүргийн бүтэц өөрчлөгдсөний зэрэгцээ (Fernandez-Gimenez and Batbuyan, 2004; Fernandez-Gimenez, 2001, Fernandez-Gimenez, 1999), Монгол улсын хэмжээнд мал сүргийн тоо толгой жил бүр маш их хэлбэлздэг хэдий ч, сүүлийн хорин жилийн хугацаанд бараг гурав


дахин өсөж, ойролцоогоор 60 орчим сая толгойд хүрчээ (Үндэсний статистикийн хороо, 2016). Үүнээс улбаалан, хүн амын суурьшил, усны эх булаг орчимд бэлчээрийн талхигдал нүүрлэж, улмаар мал болон зэрлэг амьтдын бэлчээрийн тэтгэх даац буурах үйл явц хааяагүй түгээмэл ажиглагдах болжээ (Reading et al., 2006; Stump et al., 2005).

Эрдэс, ашигт малтмалын эрэл хайгуул, ашиглалт нэн хурдацтай өсөн нэмэгдэж байна. Монгол улсын нийт дэвсгэр нутгийн 8 хувийг эзлэх тайлбайд 2014 оны 4-р сарын байдлаар эрдэс, ашигт малтмал, газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдоод байна (АМГ, 2014). Уул уурхайн үйл ажиллагаанаас газар ба усны экосистемд үзүүлэх шууд нөлөө нь тухайн нөлөөллийн эх үүсвэрээр хязгаарлагдахгүй. Зэрлэг амьтдад тулгараад буй хамгийн уршигтай аюул хөнөөл бол амьтдын шилжилт хөдөлгөөнд саад учруулж буй уул уурхайн төслийн үйл ажиллагаатай холбоотой зам тээврийн дэд бүтэц ба замын хөдөлгөөний эрчим юм (Batsaikhan et al., 2014; Ito et al., 2005; Ito et al., 2013; Kaczensky et al., 2011; Kaczensky et al., 2006; Olson, 2012; Lkhagvasuren et al., 2011; Lkhagvasuren 2000).

### Зураг 1: Монгол орны ландшафт, экологийн бус нутаг



**Зураг 2:** Судалгаанд хамрагдсан бус нутаг: Монгол орны төв болон умард хэсгийн экологийн бус нутгууд (Chimed-Ochir et al. 2010)



## 1.2. БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

Байгаль хамгааллын цэгцтэй төлөвлөлт нь тухайн төлөвлөж буй газар нутгийн хүрээнд илэрч байгаа экосистем, байгалийн бүлгэмдэл, угуул зүйлийн амьдрах орчны ихээхэн хэсгийг хамтад нь төлөөлж чадахуйц экологийн хувьд чухал ач холбогдол бүхий газар нутгийн сүлжээг илрүүлэн тогтооход шинжлэх ухааны үндэслэлтэй арга юм<sup>1</sup>. Байгаль хамгааллын үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлэхийн тулд амьдрах орчны тархац, учирч болох аюул болон болзошгүй сөрөг нөлөөллийг бус нутгийн болон ландшафтын түвшинд авч үзэж, байгаль хамгааллын тэргүүлэх ач холбогдлыг системтэй тодорхойлох нь чухал (Margules & Pressey, 2000; Groves, 2003). Байгаль хамгааллын төлөвлөлтийн

эцсийн бүтээгдэхүүн нь тухайн нутгийн уугуул зүйлүүд ба экосистемийн олон янз байдал, тэдгээрийн тархацыг бүрэн төлөөлж чадахуйц байдлаар сонгосон экологийн хувьд чухал ач холбогдолтой, хамгаалах шаардлагатай газар нутгийн сүлжээ юм. Ихэнхдээ байгаль хамгааллын системтэй төлөвлөлтт боловсруулахад орон зайн дун шинжилгээ хийхэд өөрөө оновчтой сонголт хийх чадвартай "Марксан" зэрэг программ ашигладаг (Ball and Possingham 2000). Энэ программ амьдрах орчны хувьд аливаа биологийн бүрдэл хэсгийг тэтгэж чадахуйц байхын зэрэгцээ газар нутгийн эзлэх талбай аль болох бага байх зарчим дээр үндэслэгдсэн (Pressey et al. 1997, Ball 2000, Ball and Possingham 2000).

<sup>1</sup> "Экологийн бус нутгийн үнэлгээний аргачлал"-ыг ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн 2014 оны 5-р сарын 27-ний өдрийн хуралдаанаар баталсан.

Дээр дурдсан арга нь Groves et al. (2002), Groves (2003) болон Higgins & Esselman (2006) нарын боловсруулсан экологийн

бүс нутгийн үнэлгээний аргачлал ба стандартад тулгуурлажээ. Экологийн бүс нутгийн үнэлгээ нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд: (1) тухайн судалгаанд хамрагдсан бүс нутгийн биологийн олон янз байдлыг хамтатган төлөөлж чадахуйц зүйл, экосистем, олон янз байдлыг илэрхийлэх бусад биологийн бүрэлдхүүнийг тодорхойлж, газрын зурагт буулгах; (2) хамгаалахаар төлөвлөж буй биологийн олон янз байдлын экологи, эволюцийн шаардлагыг удаан хугацааны туршид тэтгэхүйц тоо толгойн элбэгшил, тархацыг тооцсон зорилтыг дэвшүүлэх; (3) хамгаалахаар зорьж буй биологийн олон янз байдлын харьцангуй амьдрах чадвар ба экологийн цогц байдал, түүнчлэн учрах аюул уршиг, тархац (бүлгэмдэл, популяци, экосистем гэх мэт )-ын төлөв байдлыг үнэлэх; (4) дээр дурдсан мэдээллийг ашиглан экологийн хувьд цогц байдлаа харьцангуй сайн хадгалсан, ирээдүйд учирч болзошгүй аюул, уршийн хамгийн бага эрсдлийг тэсвэрлэж чадах, хамтдаа төлөөлүүлэн хамгаалах зорилтыг хангахуйц биологийн олон янз байдлын элементийн тохиолдоцыг илрүүлэн тогтоох зэрэг болно.

### 1.3. УРЬД ХИЙГДЭЖ БАЙСАН БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ГАЗРУУДЫГ ТОГООХ ЧИГЛЭЛИЙН СУДАЛГААНЫ АЖЛУУДЫН ТОЙМ

Монгол улс магадгүй, дэлхийн хамгийн эртний, хамгийн удаан хугацаанд хамгаалагдсан газар нутаг болох Богд хан уулын дархан цаазтай газрыг 1778 онд байгуулжээ. Монгол улсын Байгаль орчны яам 1996 онд Биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны Үндэсний хөтөлбөрийг хэвлүүлсэн байна (БОЯ, 1996). Энэ хөтөлбөрт Дархан цаазтай газар 8, Байгалийн цогцолборт газар 40, Байгалийн нөөц ба Дурсгалт газар 37 тус тус шинээр байгуулахыг санал болгожээ. Дээр дурдсан санал зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд, 2008 оны

байдлаар эдгээр газруудын 40 орчим хувийг нь улсын тусгай хамгаалалтай газарт хамруулсан байна. (Chimed-Ochir et al., 2010). Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр (1998)-т нийт газар нутгийн 30 хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад хамруулах зорилт дэвшүүлжээ. УИХ-ын 13 тоот тогтоолд дурдсан уг зорилтын 15 хувийг нь улсын тусгай хамгаалалтад, үлдэх 15 хувийг орон нутгийн тусгай хамгаалалтад тус тус хамруулахаар заасан.


Өнөөдрийн байдлаар, Монгол улсын нийт дэвсгэр нутгийн 17.4 хувь буюу ойролцоогоор 27.2 сая га газрыг хамарсан улсын тусгай хамгаалалтай 90 газрыг байгуулаад байна (БОНХАЖЯ, 2015). Үүнээс гадна, Монгол улс 6 газрыг ЮНЕСКО-гийн Шим мандлын нөөц газар (UNESCO, 2011a)-т, 2 газрыг Дэлхийн өв (UNESCO, 2011b)-д, мөн 11 газрыг олон улсын ус намгархаг газрыг хамгаалах RAMSAR-ийн конвенци (Ramsar, 2011)-д тус тус бүртгүүлжээ. Bird Life International олон улсын байгууллагаас Монгол улсад 70 газрыг Шувуудад чухал газар (IBAs) хэмээн тодорхойлжээ (Nyambayar and Tseveenmyadag, 2009). “Биологийн олон янз байдлын орхигдлын үнэлгээ” (Chimed-Ochir et al., 2010)-гээр тусгай хамгаалалтад авах шаардлагатай 34 газрыг улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд шинээр хамруулахаар санал болгосны 6 нь бидний судалгаанд хамрагдсан бүс нутагт оршиж байгаа юм.



Судалгааны бус нутагт улсын тусгай хамгаалалттай 29 газар бүхэлдээ буюу хэсэгчилсэн байдлаар хамрагдсан нь нийт 56,000 км<sup>2</sup> буюу судалгааны бус нутгийн

16 хувийг эзлэж байна. Эдгээр газар нутаг нь зайлшгүй хамгаалах шаардлагатай газар нутгийг бүрэлдүүлэх эх суурь болов.

**Зураг 3:** Зайлшгүй хамгаалах шаардлагатай буюу экологийн хувьд чухал ач холбогдолтой газрыг тогтоох үйл явц



#### 14. ХӨГЖЛИЙГ БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨ БАГАТАЙ ТӨЛӨВЛӨХ НЬ

Дэ Нэйче Консерванси (TNC) байгууллага нь Монгол улсын засгийн газартай хамтран уул уурхай болон хөгжлийн бусад асуудлыг уламжлалт бэлчээрийн мал аж ахуй болон амьдрах орчныг хамгаалах асуудалтай тэнцвэртэй хослуулах “Хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь” хэмээх шинжлэх ухааны үндэслэлтэй аргачлалыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна (Kiesecker et al., 2009; Kiesecker et al., 2010; McKenney and Kiesecker, 2010; Kiesecker et al., 2011; Kiesecker et al., 2013). Хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай

төлөвлөх нь аливаа нэг хөгжлийн төсөл хөтөлбөрөөр хязгаарлагдахгүй, харин ландшафтын түвшинд байгальд үзүүлж буй хөгжлийн хуримтлагдах нөлөөллийг тодорхойлох замаар тогтвортой хөгжлийн шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлж чадахуйц аргачлал юм. Ландшафтын түвшинд байгаль хамгаалах төлөвлөгөө боловсруулах нь нөлөөллийг бууруулах уламжлалт аргыг эрс сайжруулах боломж бүрдүүлнэ. Хөгжлийг байгаль орчинд нөлөөлөл багатай төлөвлөх нь хамгааллын төлөвлөлтийг “нөлөөллийг бууруулах шатлал”-тай хослуулснаар

эхлээд нөлөөллөөс зайлсхийх, дараа нь бууруулах/нөхөн сэргээх, эцэст нь дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлснээр нөлөөллийг бууруулахад нэн чухал дараах асуудлыг шийдвэрлэх юм. Үүнд:

- Зэрлэг амьтад, тэдгээрийн амьдрах орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тухайн нэг төслийн хэмжээнд бус харин ландшафтын түвшинд авч үзэн, хуримтлагдах нөлөөллийг тодорхойлох,
- Хөгжлийн төлөвлөгөө болон байгаль хамгааллын тэргүүлэх зорилтуудын хооронд үүсэж болзошгүй зөрчлийг хөнөөл уршиг учирахаас өмнө урьдчилан тодорхойлох,
- Зэрлэг амьтан болон эмзэг байгалийн унаган төрхөд нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх, үзүүлэх үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах боломжийг тодорхойлох, хөгжил болон байгаль хамгааллын хэрэгцээ шаардлагыг тэнцвэртэй хослуулах,

нөлөөллийг бууруулах хамгийн үр ашигтай арга замыг боловсруулах,

- Төслийн нөлөөллөөс аль тохиолдолд зайлсхийх, аль тохиолдолд дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэх шаардлагатайг тогтоох,
- Экологийн хувьд ижил (хөгжлийн нөлөөлөлд өртсөнтэй ижил хэв шинжийн экосистем, зэрлэг амьтдын зүйл), ландшафтын түвшний байгаль хамгааллын зорилгод хувь нэмэр болохуйц, нөлөөлөлд өртсөн газартай ойр байршилтай, байгаль хамгааллын хамгийн үр ашигтай байж чадахуйц дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг тодорхойлох .

Хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх аргачлал нь хоёр ялгаатай орон



зайн цар хүрээнд хэрэгждэг. Эхний үе шатанд, ландшафтын хүрээнд (Хангай, Хөвсгөлийн экологийн бус нутаг) байгаль хамгааллын чухал ач холбогдолтой газруудыг тодорхойлох, тухайн бус нутагт хуримтлагдах нөлөөллийг тогтоох, байгаль хамгаалал ба хөгжлийн зорилт хоёрын хооронд зөрчил үүсч болзошгүй газруудыг тогтоох, нөлөөллийг хаана нэн яаралтай бууруулах, зайлсхийх талаар шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах (1 ба 2 дугаар үе шатыг үзнэ үү) зэрэг асуудлуудыг авч үзнэ. Удаах үе шатанд “Хөгжлийг нөлөө багатай төлөвлөх нь” аргачлалыг тухайн төсөл хэрэгжүүлэх газарт (жишээ нь уурхайн эдэлбэр) хэрэглэх бөгөөд тухайн төслийн үзүүлэх нөлөөлөл, дүйцүүлэн хамгаалах боломжийг тодорхойлох, мөн шаардлагатай тохиолдолд тэдгээр нөлөөллийг бууруулах арга замыг боловсруулна (3 ба 4 дүгээр үе шатыг үзнэ үү).

Ландшафтын түвшинд:

1. Ландшафтын түвшинд байгаль хамгааллыг төлөвлөх (эсвэл урьд өмнө хийгдсэн байгаль хамгааллын төлөвлөгөө тухайлбал, Экологийн бус нутгийн үнэлгээг ашиглах),
2. Экологийн эмзэг байдал болон дахин сэргээгдэшгүй төлөв байдлыг харгалzan ландшафтын түвшний байгаль хамгааллын төлөвлөлтийг нөлөөллийг бууруулах дараалалтай хослуулан зөрчил үүсч болзошгүй газруудыг тогтоох,

Төслийн түвшинд:

1. Хөгжлийн төслийн үлдэгдэл нөлөөллийг тодорхойлж, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх хамгийн зохистой экологийн хувьд чухал ач холбогдолтой газар нутгийг сонгох,
2. Байгаль хамгаалах эцсийн зорилтод дүйцүүлэн хамгааллын оруулах хувь нэмрийг тооцох үйл явц байх болно.

Энэ судалгаа нь ландшафтын түвшний дүн шинжилгээ хийх замаар төлөвлөж буй хөгжлийн (уул уурхай, эрчим хүч) нөлөөллөөс аль хэсэгт зайлсхийх, ямар тохиолдолд нөлөөллийг бууруулах эсвэл дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэх нь зохистой вэ гэсэн чухал асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ (Kiesecker et al. 2010, Thorne et al. 2006). Байгаль хамгааллын төлөвлөлт нь, тухайлбал экологийн бус нутгийн үнэлгээ нь, зэрлэг амьтны эрүүл амьдрах орчин болон хүний хэрэгцээг хангахад шаардлагатай, аливаа өөрчлөлтөд дасан зохицох чадвартай, томоохон экосистемийг хамгаалах, байгаль хамгааллын зорилттой уялсан нөлөөллийг бууруулах бүтцийг бий болгодог. Ландшафтын түвшний төлөвлөлтийг нөлөөллийг бууруулах үе шатай хослуулах нь нөлөөллийг тухайн төслийн хэмжээнд авч үздэг уламжлалт аргатай харьцуулахад, эрс ялгаатай давуу талыг агуулдаг. Учир нь, 1) өнөөгийн болон ирээдүйн хөгжлийн хуримтлагдах нөлөөллийг авч үздэг; 2) нөлөөллийг бууруулах үе шатыг хэрэгжүүлэхэд шаардлагатай (зайлсхийх эсвэл дүйцүүлэн хамгаалах гэх мэт) бус нутгийн түвшний суурь мэдээллийг бүрэлдүүлэх; 3) нөлөөлөлд хамгийн их өртсөн экосистем болон зүйлийг хамгаалахад чиглэсэн дүйцүүлэн хамгаалах, хамгийн үр ашигтай арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой.

## 1.5. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ АШИГЛАХ НЬ

Энэ судалгааны үндсэн зорилго нь зэрлэг амьтны идээшин амьдрах орчин болон шилжилт хөдөлгөөнд чухал холбогдолтой, харьцангуй хөндөгдөөгүй байгаа түгээмэл экосистемийн цөм хэсгийг хамгаалах, менежмент хийх замаар судалгаанд хамрагдаж буй газар нутгийн төлөөлөл болох биологийн олон янз байдал ба экологийн үйл явцыг тэтгэж чадах газар нутгийг тогтооход чиглэгдсэн. Монгол улсын төрөөс дэвшигүүлсэн, нийт нутаг дэвсгэрийн 30 хүртэлх хувийг хамгаалалттай газар нутгийн



сүлжээнд хамруулах бодлогыг (УИХ, 2008) хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс хамгаалах шаардлагатай газрыг экосистемийн түвшинд дараах шалгуурыг ашиглан тогтоолоо. Үүнд: экологийн нөхцөл байдлын хувьд, хүний үйл ажиллагаанд хамгийн бага өртсөн, хамрах талбайн хэмжээ нь хамгийн бага байх, уул уурхайн хөгжлийн хэтийн төлөвтэй байгаль экологийн зорилт уялдсан байх зэрэг шалгуурыг дурдаж болно. Эдгээр газрыг тогтооход, бэлэн байгаа мэдээлэл дээр тулгуурлан 350,000 км<sup>2</sup> талбай бүхий өргөн уудам бүс нутагт нийцсэн, байгаль хамгааллын төлөвлөлт хийх аргачлалыг боловсруулан ашиглав. Судалгааны үр дүнд байгаль хамгаалал, хөгжил, газар ашиглалтын зохистой төлөвлөлтийг ландшафтын түвшинд авч үзэн, шийдвэр гаргахад дэмжлэг болохуйц мэдээллийн систем бүрэлдсэн болно.

Судалгааны үр дүнд тогтоосон хамгаалах шаардлагатай газар нутаг болон мэдээллийн системийг байгалийн баялгийн менежмент ба байгаль

хамгааллын дараах үйл ажиллагаанд ашиглаж болно. Үүнд:

- Тусгай хамгаалалттай газрын сүлжээг төлөвлөх, өргөтгөх: Монгол улсын Тусгай хамгаалалттай газрын үндэсний хөтөлбөрт (1998 онд батлагдсан) тусгагдсан Монгол улсын нийт газар нутгийн 30 хүртэлх хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах зорилтыг хэрэгжүүлэхэд энэ судалгааны үр дүнг ашиглах боломжтой. Улсын Их Хурлын 13 тоот тогтоолд газар нутгийн 15 хувийг улсын тусгай хамгаалалтад, 15 хувийг орон нутгийн хамгаалалтад тус тус хамруулах замаар дээр дурдсан 30 хүртэлх хувийг хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхээр заажээ. Өнөөгийн байдлаар, Монгол улс нийт нутаг дэвсгэрийнхээ 17.4 орчим хувь буюу 27.2 сая га газрыг хамарсан улсын тусгай хамгаалалтай 90 газрын сүлжээг байгуулаад байгаа билээ (БОНХАЖЯ, 2015). Бидний судалгааны үр дүн нь улс болон



аймаг, орон нутгийн цар хүрээнд: 1) Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 30 хүртэлх хувийг тусгай хамгаалалтад авах зорилтыг биелүүлэх, 2) хамгаалалтад авах газрыг эрэмбэлэх, одоогийн тусгай хамгаалалтай газруудын менежментийн чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг болж чадах юм.

- Хөгжил ба байгаль хамгааллын хооронд үүсч болзошгүй сөргөлдөөн зөрчлийг төлөвлөлтийн шатанд илрүүлэх хүрээнд: Хөгжил болон байгаль хамгааллын сонирхол хооронд үүсч болзошгүй орон зайн давхцалыг урьдчилан тогтоосноор хөгжлийн болон байгаль хамгаалах зорилтуудыг тэнцвэртэй уялдуулах замаар хөгжлөөс учирч болох нөлөөллийг үр дүнтэй бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх боломж бүрэлдэнэ.
- Уул уурхай болон газрын тос олборлох үйл ажиллагааны нөлөөллийг бууруулах хүрээнд: Нөлөөллөөс зайлсхийх, нөлөөллийг бууруулах зохистой арга хэмжээг хэрэгжүүлэх болон дүйцүүлэн хамгаалах замаар нөлөөллийг бууруулах үе шатыг

хэрэгжүүлэх бүтцийг бий болгосноор шинжлэх ухааны үндэслэлтэй, мэдээлэлд тулгуурласан шийдвэр гаргах явцыг дэмжих боломжтой.

- Дүйцүүлэн хамгааллыг төлөвлөх хүрээнд: Өнөөгийн болон ирээдүйн хөгжлийн хуримтлагдах нөлөөллийн хүрээнд байгаль хамгааллын үнэ цэнийг тодорхойлсноор, хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангахын зэрэгцээ ландшафтын түвшний байгаль хамгааллын зорилтыг биелүүлэхэд хувь нэмэр оруулж чадахуйц дүйцүүлэн хамгааллыг төлөвлөхөд шаардлагатай үндэс суурийг бий болгоход дэмжлэг болно.
- Газар ашиглалтыг төлөвлөх хүрээнд: Хамгаалах шаардлагатай газар нутгууд, түүнтэй холбоотой мэдээллийг улс, аймаг, сумын газар ашиглалтын төлөвлөлтед ашиглах боломжтой. Бус нутгийн амьдрах орчны хэв шинж, малчин айл өрхийн нягтшил, газар ашиглалтын бусад мэдээллийт ашиглан, бэлчээрийн зохистой менежмент хийх, зэрлэг амьтан ба малын бэлчээрийн өрсөлдөөнийг бууруулах, бэлчээрийн нөөц газрыг тогтоох ба менежментийн арга хэмжээг тодорхойлох боломж бүрдэнэ.
- Экосистем ба экологийн үйл явцын талаарх судалгаа шинжилгээ, мэдлэгийг байнга сайжруулах ажлын үндэслэл болох хүрээнд: Ургамалшил болон экосистемийн зураглал, зүйлийн амьдрах орчны тархацын загвар нь амьтан, ургамлын зүйлийн эсвэл ургамалшлын судалгааны чиглэлийг тодорхойлох суурь болно. Судалгааны ажлын үр дүнг ургамалшил, экосистемийн зураг болон зүйлийн амьдрах орчны тархацын загварыг цаашид сайжруулахад ашиглах боломжтой.



## 2.0 АРГА ЗҮЙ БА ҮР ДҮН

### 2.1. ТОЙМ

Хангай, Хөвсгөлийн экологийн бүс нутгийн төлөөлөл болох биологийн олон янз байдал, экологийн үйл явцыг тэтгэж чадах, хамгаалах шаардлагатай газар нутгийг тодорхойлоход энэ судалгааны ажлын зорилго оршино. Энэ бүс нутгийн биологийн олон янз байдлыг тодорхойлох зорилгоор газрын экосистемийн ангиллыг боловсруулж, био-газарзүйн муж, экосистемийн хэв шинж болон газрын гадаргын 99 ялгаатай хэв шинжийг ялгасан зургийг 2.2.1-р хэсэг, хүснэгт 1; 2; зураг 5; 6-аас тус тус үзнэ үү. Хамгаалах шаардлагатай газар нутгийг тогтооход дараах шалгууруудыг ашигласан. Үүнд:

**Төлөөллийн шалгуур:** Биологийн олон янз байдал тус бүрийн хувьд экологи, эволюцийн урт хугацааны үйл явцыг тэтгэхэд шаардлагатай, тодорхой тоо болон хэмжээг хамгаалах зорилгыг хангасан байх. Хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлын бүрдэл хэсгийг газрын экосистемийн ангиллаар

тодорхойлж, судалгааны бүс нутагт оршин буй экосистемийн хэв шинж тус бүрийн газарзүйн тархацын хэсгийг төлөөлөл болгох замаар хамгаалах.

**Экологийн нөхцөл байдлын шалгуур:** Бидэнд байгаа явцуу мэдлэг, дутмаг мэдээллийн хүрээнд хүний үйл ажиллагааны нөлөөллийн индексийг ашиглан экологийн цогц байдал эсвэл амьдрах чадвар хамгийн сайн биологийн олон янз байдлын бүрдэл хэсгийг агуулж буй газар нутгийг илүүд үзэж, сонгох,

**Үр дүнтэй байдлын шалгуур:** Өнөөгийн болон ирээдүйн хөгжлийн үйл ажиллагаанаас үзүүлэх аюул уршгийг даван туулах чадвартай, биологийн олон янз байдлын бүрдэл хэсгийг хамгаалах зорилтыг хангаж чадахуйц, хамгийн бага талбай эзлэх, хамгийн цөөн тоотой хамгаалах газар нутгийг илрүүлэх,

**Амьдрах орчны холбогдох байдал:** Олон жижиг газрыг сонгохоос илүүтэй

хоорондоо ойр дөт байршилтай, цөөн, уудам газрыг сонгох зарчим баримтлав. Харин, боломжтой тохиолдолд үргэлжилсэн уудам газрыг сонгосон болно.

Хамгаалах шаардлагатай газар нутгийн сонголтыг дор дурдсан үе шат ба бүрэлдхүүнд тулгуурлан гүйцэтгэв. Үүнд:

**Эхний алхам: Улсын тусгай хамгаалалтай газар нутаг.** Бид судалгааны бүс нутагт оршиж буй дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар зэрэг тусгай хамгаалалтай бүх газар нутгийн орчны бүсийг хасаж хилийн цэсийг (БОНХАЖЯ, 2015) газрын зурагт буулгасан. Эдгээр газар нутаг нь хамгаалах шаардлагатай газар нутгийг шинээр тогтоох, төлөвлөх үйл ажиллагааны эхний алхам, үндсэн суурь болсон юм.

**Удаах алхам: Хамгаалах шаардлагатай бусад газар нутаг.** Бид судалгааны явцад одоогийн улсын тусгай хамгаалалтай газар нутгуудыг хамгаалах шаардлагатай бусад газруудын суурь болгож оруулаад, бусад хамгааллын үнэлгээг харгалzan цаашид хамгаалах шаардлагатай газруудыг нэмж тогтоов. Үүнд:

- Тусгай хамгаалалтад авахаар санал болгож буй газар нутгууд (Др. Б.Оюунгэрэл, Газарзүй, Геоэкологийн хүрээлэн, ШУА)
  - Отгонтэнгэрийн өргөтгөл
  - Хөх нуур, Бумбат
  - Ноён Хангайн өргөтгөл
  - Хангайн өргөтгөл,
- ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын гүйцэтгэсэн Биологийн олон янз байдлын орхигдлын үнэлгээ (Chimed-Ochir et al., 2010)-гээр
  - 6 газар
- ДБХС -ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын дэвшүүлсэн Алтай-Саяны

экологийн бүс нутгийн хамгаалах шаардлагатай газар (2015)

**Гутгаар алхам: Экосистемийн төлөөлөл газрын сонголт.** Дээр дурдсан одоогийн улсын тусгай хамгаалалттай газрууд болон хамгаалах шаардлагатай бусад газраас гадна бид экосистемийн төлөөллийг хангах зорилтыг хангахуйц хэд хэдэн экосистемийн нэмэлт газрыг газарзүйн мэдээллийн систем (ГМС)-ийн дүн шинжилгээ ашиглан тогтоосон. Энэ дүн шинжилгээ нь үндсэн гурван бүрэлдхүүн хэсэгтэй. Үүнд:

- Нэгдүгээрт, **биологийн олон янз байдлын бүрдэл хэсэг**, тухайлбал газрын экосистеми ба амьдрах орчны хэв шинжийг газрын зурагт буулгахын тулд био-газарзүйн мужлал, ургамалшлын хэв шинж, биофизик орчин, газрын гадаргын хэлбэр зэргийг ашиглан ГМС-н загвар боловсруулан ашиглав (2.2.1 хэсэгт буй тайлбарыг үзнэ үү).
- Хоёрдугаарт, бэлчээр ашиглалтын эрчим ихтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай, нөгөө талаас, экологийн хувьд сүйтгэгдсэн газрыг тодорхойлох зорилгоор, хүний үйл ажиллагааг төлөөлөх орон зайн мэдээлэл дээр тулгуурлан **нөлөөллийн индекс** (2.4-т тодорхойлсон)-ийг тооцоолов.
- Гуравдугаарт, байгаль хамгааллын төлөвлөлт хийхэд ашигладаг “МАРКСАН” программ хангамжийг ашиглан, улсын тусгай хамгаалалтай газар нутаг, шувуудад чухал газруудыг багтаасан, экосистемийн төлөөллийн зорилтыг хангасан, экологийн нөхцөл байдал ба холбогдох байдлын шалгуурыг хангахуйц **хамгаалах шаардлагатай газар нутгийг оновчтой сонгосон** (2.5-2.6-д буй тайлбарыг үзнэ үү).



**Дэгээр алхам. Судлаач - Шинжээчдийн санал, зөвлөмж.** Бид 2015 оны 4-11-р сард судалгааны зөвлөх багийн гишүүдийн хүрээнд олон удаа хэсэгчилсэн уулзалт, ярилцлага зохион байгуулж, хамгаалах шаардлагатай газар нутагт хамруулан сонгосон газруудын тухай санал, зөвлөмжийг хэлэлцэв. Судлаач Д.Даш (ШУА-ийн Газарзүй, Геоэкологийн хүрээлэн) 2016 оны 6-9-р сард Монгол орны Баруун болон Төвийн бүсийн зарим аймаг, орон нутгийн холбогдох байгууллага, хүмүүстэй уулзалт зохион, хамтран ажиллаж, хамгаалах шаардлагатай хэмээн сонгосон газрын тухай хэлэлцүүлэг өрнүүлж, холбогдох мэргэжилтнүүдийн саналыг тусган зарим газрыг нэмж тодорхойлсон болно. Эдгээр сонгосон газрыг Зураг 10 болон Хавсралт 3-аас үзнэ үү.

## 2.2. ХАМГААЛАХ ШААРДЛАГАТАЙ БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН БҮРДЭЛ

Байгаль хамгааллын цэгцтэй төлөвлөлтөд хамгаалах шаардлагатай биологийн олон

янз байдлын урт хугацааны туршид эрүүл оршин амьдрахад шаардлагатай наад захын шаардлагыг хангахуйц биологийн бүхий л бүрдэл хэсэг, тэдгээрийн орон зайн тархац, төлөв байдлыг нь тусгасан хамгаалах зорилтыг тодорхойлох нь нэн чухал байдаг. Мэдлэг, мэдээллийн дутмаг байдал ба биологийн тогтолцооны нарийн төвөгтэй зохион байгуулалт зэргийн улмаас хамгаалбал зохих хэдэн мянян биологийн олон янз байдлын бүрдэл хэсгийг нэг бүрчлэн тодорхойлох боломжгүй ба шаардлага ч байхгүй юм. Тиймээс тархац нутгийг нь газрын зурагт оруулах боломж бүхий мэдээллийн олдоц бүхий, тухайн бүс нутгийн биологийн олон янз байдлын бүрдэл хэсгийг хамгийн сайн төлөөлж чадахуйц хүрээлэн буй орчны шинж чанар, хэв шинж болон зүйл эсвэл биологийн олон янз байдлын бүрдэл хэсгийг сонгон авах зарчмыг баримталдаг.

Биологийн олон янз байдал нь орон зайн янз бүрийн тархацтай байхын сацуу экологийн ялгаатай эрэмбэд оршдог. Иймд бүс нутгийн хүрээнд байгаль хамгааллын

төлөвлөлтийг хийхдээ, биологийн зүйлээс экосистем хүртэлх тогтоцын эрэмбэ болон орон зайн хэмжээг харгалзан үзэх хэрэгтэй (Noss 1996, Margules & Pressey 2003, Groves 2003). Биологийн олон янз байдлын бүрдэл хэсэг нь Poiani нарын (2000) тодорхойлсноор, орон нутгийн, дунд хэмжээтэй, уудам болон бус нутгийн хэмжээний хэмээх орон зайн ялгаатай тархацтай байж болно (Зураг 4).

Экологийн бус нутгийн үнэлгээний явцад хамгаалах биологийн олон янз байдлыг сонгохдоо ерөнхий болон нарийн шүүлтүүр гэсэн шалгуурыг түгээмэл ашигладаг. Үүнд, бүх экосистемүүд (ерөнхий шүүлтүүр) болон зөвхөн экосистемээр төлөөлүүлж болохооргүй тоо толгой ховордсон, маш тодорхой амьдрах орчин шаарддаг, уудам орон зайд шилжин нүүдэллэдэг зүйл амьтад (нарийн шүүлтүүр) багтана (Groves et al 2002; Groves 2003). Ерөнхий шүүлтүүр ашиглах нь төлөөлөл экосистемийг хамгаалах боломж олгох ба түгээмэл тархацтай, сайн судлагдаагүй эсвэл тархац нь тогтоогдоогүй бүлгэмдэл болон зүйлүүд, тэдгээрийн эволюци явагддаг орчныг хамгаалах боломж олгодог гэж үздэг (Jenkins et al 1976, Hunter 1991). Байгаль хамгааллын төлөвлөлтөд зөвхөн амьтан, ургамлын зүйлийг авч үзэх нь амьдрах орчныг тэтгэж байдаг хүрээлэн буй орчны өргөн хүрээтэй үйл явц болон түгээмэл зүй тогтлыг хамгаалахад учир дутагдалтай байдаг.

Ерөнхий болон нарийн шүүлтүүрийг ашиглах нь амьдрах орчны бүтэц, үйл ажиллагаанд чухал нөлөөтэй хүрээлэн буй орчны хэв шинж, үйл явц, тогтоцыг олон шатанд авч үзэх боломж олгоно. Хүрээлэн буй орчны элдэв хэв шинж, бүтцийг ялаатай орон зайн цар хүрээнд төлөөлж чадах биологийн олон янз байдлыг хамгаалахаар сонгох нь экосистемийн динамикт хэв шинж болон уур амьсгалын өөрчлөлтийн тодорхойгүй нөхцөлд байгаль хамгааллыг зохистой төлөвлөх боломж олгодог (Hunter 1988, Halpin 1998, Groves 2003, Beier & Brost 2010, Anderson & Ferree 2010).

Энэ аргачлал нь бэлэн байгаа олдоцтой мэдээлэл дээр тулгуурлан, тухайн хамгаалах шаардлагатай газрын бүрэн төлөөлөл болж чадахуйц цөөн тооны хамгаалах амьдрах орчны олон янз байдлыг сонгох боломж олгодог тул практик ач холбогдолтой. Зүйлийн тархац болон тэдний амьдрах орчны талаар өнөөгийн бидний шинжлэх ухааны мэдлэг, мэдээлэл хомс байгаа юм. ГМС-ийн бэлэн байгаа мэдээллийг ашиглан ерөнхий шүүлтүүрээр дамжуулан экосистемийг газрын зурагт буулгах боломж бий. Энэ нь байгаль хамгааллын төлөвлөлтийг хийх үндэс болох бөгөөд дутуу байгаа мэдээллийг нөхөн ач холбогдолтой юм. Нарийн шүүлтүүрээр илрүүлэх бүлгэмдэл, зүйлийн тархацын талаарх мэдээлэл ихэнх тохиолдолд



хомс байдаг ба нарийвчилсан судалгаа шаарддаг тул орон зайн мэдээлэл нь харилцан адилгүй олдоцтой байдаг. Иймд ерөнхий боловч, нэг аргачлалаар тодорхойлсон экосистемийн ангиллыг ашиглах нь хээрийн судалгаагаар үнэмшилтэй тогтоосон боловч, орон зайн хувьд жигд бус тархацтай зүйлийн талаарх мэдээллийн дутагдалтай байдлыг орлуулах боломж олгодог давуу талтай.

Биологийн олон янз байдлын ерөнхий шүүлтүүрийг тодорхойлж, газрын зурагт буулгахын тулд бид био-газарзүйн муж, ургамалшил, геоморфологи дээр тулгуурласан экосистемийн ангиллыг боловсрууллаа. Нарийн шүүлтүүрт (Хүснэгт 3-т үзүүлсэн мэдээг үзнэ үү) Улаан дансны

жагсаалтад устаж болзошгүй, устаж байгаа, ховордож болзошгүй, эмзэг зэрэглэлээр бүртгэгдсэн нийт 29 зүйл хөхтөн, мөлхөгчид, шувуудыг хамруулав (Gombobaatar et al. 2011, Clark et al. 2006, Terbish et al. 2006). Эдгээр 29 зүйл амьтны амьдрах орчин ба тархац нутгийг газрын зурагт буулгахдаа, эрдэм шинжилгээний бүтээл, бидэнд олдсон судлаачдын ажиглалтын мэдээлэл дээр тулгуурлан зүйлийн тархацын загварыг тус тус боловсруулав. Зүйлийн тархацын загварыг эрдэм шинжилгээний бүтээл, олдсон мэдээлэл дээр тулгуурлан ГМС-ийн нарийвчлал багатай өгөгдлүүд ашиглан боловсруулсан тул тухайн зүйлийн амьдрах орчин, тархацын талаарх нарийвчлал багатай таамаглал хэлбэрийн илэрц гэж ойлгож болно.

**Зураг 4:** Хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдал

Биологийн олон янз байдлын сонгох нь: Орон зайн цар хүрээ болон биологийн олон янз байдлын бүрдэл хэсгийг Poiani et al (2000) нарын боловсруулсан загварыг үндэслэн үзүүлэв.



## 2.2.1 Газрын экосистемийн ангилал

Судалгааны бүсэд хамрагдах экосистемүүдийг тодорхойлон зураглахын тулд бид Comer et al. (2003) нарын боловсруулсан аргыг ашиглан, ургамалшлын хэв шинж, биофизик орчин, газрын гадаргын хэв шинж дээр

үндэслэн био-газарзүйн муж, газрын экосистемийн ангилал хийх орон зайн загвар боловсруулсан. Энэ ангиллаар экосистемийн 99 ялгаатай хэв шинжийг ялган тодорхойлов. Сэдэвчилсэн ангиллыг ДБХС-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын боловсруулсан Үндэсний экосистемийн ангилал (Chimed-



Ochir et al. 2010), Vostokova and Gunin (2005), Түвшинтогтох (2014) болон Hilbig (1995) нарын урьд өмнө хийгдсэн ургамалшил болон амьдрах орчны ангиллын судалгааны мэдээ, газрын зурагт үндэслэн боловсруулсан. Бидний боловсруулсан газрын экосистемийн орон зайн загвар нь бус нутгийн болон Монгол орны ургамалшил, экосистемийн зураг (Chimed-Ochir et al. 2010; Vostokova and Gunin 2005) зэрэг урьд өмнөх судалгааны бүтээл, орон зайн мэдээллийг ашиглан тогтоосон хүрээлэн буй орчны хүчин зүйлүүд ба биофизикийн босго утгууд дээр үндэслэгдсэн. Мэдээллийн эх сурвалжийг Хүснэгт 1-т үзүүлэв. Экосистем ба амьдрах орчны тархацыг Хүснэгт 2-т үзүүлэв. Арга зүйг Хавсралт 5-д илүү дэлгэрэнгүй тайлбарлав.

### Үе шат I: Био-газарзүйн муж

Био-газарзүйн муж нь бус нутгийн уур амьсгал ба физик газарзүйн ерөнхий хэв шинж, тэдгээрээс хамааралтай орших зүйлийн ба генетик олон хэлбэрийг

төлөөлнө. Судалгааны бус нутагт тархсан дийлэнх экосистемийн хэв шинжийг био-газарзүйн мужаар ялгах нь хүрээлэн буй орчны хэв шинж, зүйлийн олон янз байдлын хувьд ялгаатай байдлыг тодорхойлох ач холбогдолтой. Улмаар судалгааны бус нутгийн хүрээнд хамгаалах шаардлагатай газар нутгийг сонгох үйл явцад газарзүйн хувьд эдгээр ялгаатай байдал олон давтагдаж байгаа газрыг сонгон хамгаалах боломж олгох давуу талтай. Газарзүйн хувьд ийнхүү давтагдах байдлыг хангах нь цаг уурын гамшигт үзэгдэл, өвчин эсвэл харь зүйл зэрэг хөнөөлөөс болж биологийн олон янз байдал тодорхой нэг газар нутагт устаж болзошгүй байдлаас сэргийлэх ач холбогдолтой. Энэ судалгаанд био-газарзүйн мужийг тодорхойлж, газрын зурагт буулгахдаа бид Др. Д.Дашийн (2007) тодорхойлсоны дагуу Хангай, Хөвсгөл хэмээх 2 дэд бусэд ангилав (Зураг 1 ба 2).

### Үе шат II: Газрын экосистем

Экосистем нь ерөнхийдөө шим (ургамал,

амьтан) ба биет (хүрээлэн буй физик орчны шинж чанар, үйл явц) бүрэлдэхүүн хэсгүүдээр тодорхойлогддог бөгөөд физик орчны үйл явцаас хамаарч орон зайд, тархацын хэв шинжээр ялгаатай байдаг. Бид экосистемийг орон зайн цар хүрээгээр хоёр түвшинд ангилж зураглав. Нэгдүгээрт, ерөнхий хэв шинж болох өндөршил, ургамлын бүтээмж, биомассаар тодорхойлогдох уудам орон зайд тархдаг хуурай хээр, уулын хээр зэрэг түгээмэл экосистемийг газрын зурагт буулгасан юм. Хоёрдугаарт, газрын гадаргуу, гадаргын ус, хиймэл дагуулын зураг ашиглан харьцангуй нарийвчлалтай тогтоосон ус намгархаг газар зэрэг эрс ялгаатай өвөрмөц, жижиг хэмжээтэй экосистемийг ангилж, газрын зурагт буулгасан болно. Мэдээллийн эх сурвалжийг Хүснэгт 1-т үзүүлэв. Экосистем ба амьдрах орчны тархацыг Хүснэгт 2-т үзүүлэв. Аргачлалыг Хавсралт 5-д илүү дэлгэрэнгүй тайлбарлав.

### Үе шат III: Газрын гадаргын хэв шинж

Судалгааны бүс нутгийн 90 орчим хувьд түгээмэл экосистемийн 5 ялгаатай хэв шинж болох ой, уулын хээр, нугажуу хээр, хуурай хээр, ба цэлжүү хээр тархах ба газрын гадаргын хэв шинж, амьдрах орчныг сүйтгэх үйл явц, сукцессийн орчлоор бий болсон өөр хоорондоо ялгаатай, алаг цоог ургамлын



бүлгэмдэл тохиолдоно. Эдгээр түгээмэл экосистемийн ургамлын бүлгэмдэл нь их төлөв газрын гадаргын хэлбэр төрхийн ялгаанаас хамааралтай илэрдэг. Экологи, хүрээлэн буй орчин, генетик олон янз байдлыг үзүүлэх зорилгоор хээрийн экосистемийн ялгаатай хэв шинжийг газрын гадаргын хэв шинжид үндэслэн ангилав. Хөрсний шинж чанар, усны баланс ба бичил уур амьсгалын өөрчлөлтийг төлөөлөх Топографийн нийлмэл индекс (Gessler et al., 1995; Moore et al., 1991) болон налуу, зүг зовхисын хамаарал (Stage, 1976) зэргийг багцалсан ангилал (кластер анализ)-ын аргаар нэгтгэн, газрын гадаргын хэв шинжийг ялган тодорхойлж газрын зурагт буулгасан (Зураг 6)

**Хүснэгт 1: Газрын экосистемийн ангилал: Мэдээллийн эх сурвалж, зураглал хийсэн аргачлал** Экосистемийн хэв шинжийг (i) био-газарзүйн муж, (ii) ургамалшлын хэв шинж ба био-физик орчин, (iii) газрын гадаргын хэв шинжээр тус тус ангилав. Үүний үр дүнд, экосистемийн 99 ялгаатай хэв шинжийг ялгасан юм. Үүнд:

i. **Био-газарзүйн муж** (WWF National Gap Assessment - Chimed-Ochir et al., 2010)

Хөвсгөл

Хангай

ii. **Экосистемийн хэв шинж**

**Түгээмэл экосистем** нь уур амьсгал, хур тунадасны ерөнхий хэв шинжээр тодорхойлогдоно.

Ян сарьдаг

Уулын тундр

Тагийн нуга

Уулын хээр

Сэргүүн бүсийн шигүү ой

Сэргүүн бүсийн сийрэг ой

Нугажуу хээр

Нуга

Хээр (хуурай, хуурайдуу)

Цэлжүү хээр

Хээржүү цөл

- Өндөршил: SRTM (Jarvis et al., 2008; Lehner et al., 2008). Өндрийн хязгаар утгыг экосистем, ургамалшлын зураг болон бусад судалгаа, шинжилгээний материал дээр үндэслэн тогтоо (Chimed-Ochir et al., 2010; Vostokova and Gunin, 2005; Dash, 2009).
- Ургамлын нормчилсон ялгаврын индекс (NDVI): Ургамал ургалтын үеийн (4-р сараас 9-р сарын хооронд) 13 жилийн дундаж утга (2000-2012) (MODIS 13Q1, NASA LP DAAC, 2013). Ургамлын нормчилсон ялгаврын индекс (NDVI)-ийн хязгаарын утгыг ашиглан тогтоосон (Chimed-Ochir et al., 2010; Vostokova and Gunin 2005; Dash 2009).
- Ойн бүрхэвч: Landsat TM 2000-2012 (Hansen et al., 2013).

**Өвөрмөц экосистем** нь хөрсний чийгшил, гадаргын урсац, бичил уур амьсгал зэрэг нарийвчлалтай үзүүлэлтээр тодорхойлогдоно.

Голын татам, ус намгархаг газар

Татмын ой, шугуй

- Өндрийн тоон загвар (DEM)-аар бүтээсэн газрын гадаргын загвар (Smith et al., 2008).

Сөөгт татам

- Ойн бүрхэвч: Landsat TM 2000-2012 (Hansen et al., 2013).

Татмын нуга

- Ургамлын нормчилсон ялгаврын индекс (NDVI): Ургамал ургалтын үеийн (4-р сараас 9-р сарын хооронд) 13 жилийн дундаж утга (2000-2012) (MODIS 13Q1, NASA LP DAAC, 2013). Ургамлын нормчилсон ялгаврын индекс (NDVI)-ийн хязгаарын утгыг ашиглан тогтоосон (Chimed-Ochir et al., 2010; Vostokova and Gunin 2005; Dash 2009).

Жижиг гол, горхи, булгийн татам

- 1:200,000 масштабтай байрзүйн зургаас тоон хэлбэрт хөрвүүлсэн.

Тарамцаг элс

- Ойн бүрхэвч: Landsat TM 2000-2012 (Hansen et al., 2013).

Усны мандал

iii. **Газрын гадаргын хэв шинж** нь хөрсний чийгшил, бичил уур амьсгалын хэв шинжээр тодорхойлогдох ургамлын булгэмдлийн ялгааг нарийвчлалтай тогтоо боломж олгоно. Эдгээрийг түгээмэл тархацтай экосистемийн хэв шинжийг ялгахад ашигласан.

Эгц ар хажуу

78 метрийн ялгах чадвартай өндрийн тоон загвараар гаргаж авсан топографийн З загвараас кластер анализ ашиглан зураглал хийсэн:

Эгц өвөр энгэр

- Топографийн нийлмэл индекс (Gessler et al., 1995; Moore et al., 1991)

Ар хажуу

- Налуу, зүг зовхисийн хамаарал (Stage 1976)

Өвөр энгэр

Ухаа, гүвээт тэгш тал

Хотгор

Голын голдрил, нуур


**Хүснэгт 2: Газрын экосистемийн ангилал:** Судалгаанд хамрагдсан био-газарзүйн мужийн хүрээнд тохиолдох ялгаатай экосистемийн хэв шинжийн тархац.


Экосистемийн хэв шинж	Хөвсгөл		Хангай	
	км <sup>2</sup>	%	км <sup>2</sup>	%
<b>Түгээмэл хэв шинж</b>				
Ян сарьдаг	13	0.0	117	0.2
Уулын тундр	1,140	0.4	1,818	2
Тагийн нуга	21,216	8	7,548	10
Уулын хээр	76,355	28	17,079	22
Сэргүүн бүсийн ой				
Шигүү ой	13,345	5	10,673	14
Сийрэг ой	19,814	7	15,035	20
Нугажуу хээр	42,777	16	12,566	16
Нуга	7,959	3	1,142	1
Хээр (хуурай хээр)	67,602	25	4,628	6
Цөлжүү хээр	4,225	2		
Хээржүү цөл	1,591	1		
<b>Өвөрмөц экосистемийн хэв шинж</b>				
Голын татам, ус намгархаг газар				
Татмын ой	426	0.2	532	1
Сөөгт татам	2,768	1	910	1
Татмын нуга	5,916	2	762	1
Ус хөвөөлсөн халцгай газар	1,441	1	17	0.02
Жижиг гол, горхи, булгийн татам	2,934	1	760	1
Тарамцаг элс	1,525	1		
Усны мандал	1,061	0.4	3,022	4
Нийт талбай	272,109	100	76,609	100
Судалгаанд хамрагдсан талбайд эзлэх хувь	44 %		12 %	




**Зураг 5:** Газрын экосистемийн ангилал.

Ангилал болон түүний зураглалын аргазүй, мэдээллийн эх сурвалж зэргийг 2.2.1 бүлгээс болон Хүснэгт 1-ээс үзнэ үү.





**Зураг 6:** Газрын гадаргын хэв шинжийг өндрийн тоон загвараас боловсруулсан топографийн 2 индексэд үндэслэн боловсруулсан. Судалгааны бус нутгийн хүрээнд 7 төрлийн гадаргын хэв шинжийг ялган үзүүлэв. Бид энэ ангиллыг 1) түгээмэл экосистемийн хэв шинжийг ялгах болон 2) амьтны зүйлийн боломжит амьдрах орчны тархацын загвар боловсруулахад ашигласан.



**Хүснэгт 3:** Боломжит амьдралын орчны тархцацын загвар боловсруулах зорилгоор сонгосон амьтны зүйлийн жагсаалт

Монгол түгээмэл нэр	Англи түгээмэл нэр	Зүйлийн шинжлэх ухааны нэр	IUCN, Улаан данс		Амьтны тухай хууль	Монгол улсын улаан ном	CMS, CITES RAMSAR	IBA	Тархац нутаг хумигдсан
			Дэлхийн	Бүс нутгийн					
<b>Хөхтөн Амьттан</b>									
1	Зэрлэг цаа буга	Reindeer/Caribou	VU	EN					
2	Хандгай	Moose/Eurasian elk							
3	Хүдэр	Siberian musk deer	EN	EN					
4	Халиун буга	Red deer/Elk							
5	Хүрэн баавгай	Brown bear							
6	Халиу	Eurasian Otter							
7	Нохой зээх	Wolverine							
8	Янгир	Siberian/Asiatic ibex							
9	Аргалъ	Argali							
10	Ойн булга	Sable							
11	Монгол тарвага	Siberian marmot							
12	Ирвэс	Snow leopard							
<b>Хоёр нутагттан</b>									
13	Шивэр гулмэр	Siberian (Manchurian) salamander							
14	Модны мэлхий	Japanese tree toad							
<b>Мөлхөгч Амьттан</b>									
15	Усны мотой	Grass (ringed) snake							
<b>Шувуу</b>									
16	Хошуу галуу	Swan goose	VU	(+)					
17	Усны намрэг бүргэд	Pallas's fish-eagle	VU						
18	Цагаан сүүлт бүргэд	White-tailed eagle							
19	Ён	Lammergeier							

Монгол түгээмэл нэр	Англи түгээмэл нэр	Зүйлийн шинжлэх ухааны нэр		IUCN, Улаан данс Дэлхийн	Бус нууцийн	Амьтны тухай хууль	Монгол улсын улаан ном	CMS, CITES RAMSAR	IBA	Тархач нутаг хүмидсан
		Зүйлийн шиджлэх ухааны нэр	IUCN, Улаан данс Дэлхийн							
20 Хан бургэд	Eastern imperial eagle	<i>Aquila heliaca</i>	VU	(+)	(+)	(+)	CMS/CITES			
21 Реликт цахлай	Relict gull	<i>Larus relictus</i>	EN	(+)	(+)	(+)	CMS/CITES	(+)	VU	
22 Өгөөлэй шулганаа	White-throated bushchat	<i>Saxicola insignis</i>	NT	VU	(+)	(+)	CMS	(+)	VU	
23 Алтайн хойлог	Altai snowcock	<i>Tetraogallus altaicus</i>								(+)
24 Хархираа тогоруу	Common crane	<i>Grus grus</i>								
25 Хонин тоодог	Great bustard	<i>Otis tarda</i>	VU	(+)			CMS/CITES	(+)		
26 Цагаан тогоруу	Siberian crane	<i>Grus leucogeranus</i>	VU	(+)			CMS/CITES	(+)		
27 Хээрийн голуу	Bar-headed goose	<i>Anser indicus</i>								(+)
28 Нургийн сойр	Black-billed capercaille	<i>Tetrao parvirostris</i>								(+)
29 Угалзан бэгбээстэр	Great gray owl	<i>Strix nebulosa</i>					CMS			(+)
										(+)

Тайлбар: Устаж байгаа (CR), Устаж болзошгүй (EN), Эмзэг (VU), Ховордож болзошгүй (NT), Анхааралд өртөхөөргүй (LC), Мэдээлэл дутмаг (DD), Үнэлгээ хийгээгүй (NE)

IUCN -Дэлхийн байгаль хамгаалах холбоо, CMS – Нуудлийн зүйлийг хамгаалах олон улсын конвенци, CITES – Зэрлэг амьтан, ургамлын зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах Вашингтоны конвенци, IBA – Шувуудад чухал нутаг.



## 2.2.2 Хамгааллын төлөөлөл зүйл

Биологийн олон янз байдлын нарийн шүүлтүүр буюу ховор, ховордсон зүйлийг хамгаалах, тархацыг тогтоохын тулд дэлхийн болон бус нутгийн улаан дансанд (Gombobataar et al. 2012, Clark et al. 2006, Terbish et al. 2006) ховордлын зэрэглэлээр эрэмблэгдэж бүртгэгдсэн 29 зүйл хөхтөн, мөлхөгч ба хоёр нутагтан, шувуудыг сонгон амьдрах орчны тархацын загварыг ГМС дээр боловсрууллаа (Хүснэгт 3). Амьдрах орчны тархацын загварыг судалгааны бүтээлүүдэд тодорхойлсон амьдрах орчны тодорхойлолт, экосистемийн ангилал, газрын гадаргын хэв шинжийн ангилал дээр тулгуурлан, судлаачдын саналыг тусган боломжит мэдээллийн багц ашиглан, таамаг буюу дедуктив аргаар боловсруулсан юм (Хавсралт 2 үзнэ үү).

## 2.3. ТӨЛӨӨЛҮҮЛЭН ХАМГААЛАХ ЗОРИЛТ

Хамгаалах шаардлагатай газрыг тогтоох эхний алхам нь төлөөлүүлэн хамгаалах зорилтын цар хүрээг тогтоох асуудал байдаг. Төлөөлүүлэн хамгаалах зорилтыг тоон утгаар илэрхийлэх нь төлөөллийг хэмжих, хамгаалах шаардлагатай газрыг төлөвлөх, өөрчлөн сайжруулах, мэдээлэл

цуглуулах, дүн шинжилгээ хийх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд уян хатан, ил тод байдлыг бий болгодог (Carwardineet al., 2009) сайн талтай. Экосистемийн хувьд төлөөлүүлэн хамгаалах зорилтыг 30% байхаар тогтоосон нь Монгол улсын төрөөс нийт нутаг дэвсгэрийн 30 хүртэлх хувийг хамгаалах зорилттой нийцнэ (Монгол улсын тусгай хамгаалалтай газар нутгийн үндэсний хөтөлбөр 1998, УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоол).


Дэлхийн бусад экологийн бус нутгийн үнэлгээнд ерөнхий шүүлтүүрээр түүхэн тархац нутгийн 30 хувийг хамгаалах зорилт дэвшүүлсэн байдаг (Tear et al. 2005, Groves 2003) бөгөөд энэ нь арлын био-газарзүй, “арал маягийн амьдрах орчин”-ны (MacArthur & Wilson, 1967; Dobson, 1996; Groves 2003) онол дээр тулгуурласан амьдрах орчин - зүйлийн харилцан хамаарлын онолоос үүдэлтэй. Амьдрах орчны алдагдал нь аажмаар тухайн амьдрах орчныг шүтэн амьдардаг зүйл устахад хүргэнэ. Dobson (1996)-ны боловсруулсан зүйл ба газар нутгийн харилцан хамаарлын (Зураг 7-д үзүүлсэн) онол ёсоор, ерөнхий шүүлтүүр болох экосистемийн түүхэн тархацын 10-30 хувийг хамгаалж чадваас тухайн газарт

оршиж буй зүйлийн 55-85 хувийг хамгаалах боломжтой ажээ. Хуурай гандуу нутагт ургамлын бүтээмж бага, амьдрах орчны өөрчлөлт ихтэй байдгаас зэрлэг амьтны зүйлийн амьдрах орчны тархацын цар хүрээ харилцан адилгүй байх тул дээрх онолын үзэл баримтлал бүрэн нийцэхгүй байж болно.

Мэдлэг, мэдээлэл дутмаг нөхцөлд хамгааллын зорилтыг тодорхойлоход бэрхшээлтэй. Цөөн хэдэн амьтны зүйлийн хувьд удаан хугацааны туршид оршин тогтоход шаардлагатай амьдрах орчны тархац, нийт популяцийн тоо хэмжээ, популяцийн нягтшлын нарийвчилсан судалгаа хийгдсэн байдаг. Иймээс төлөөлүүлэн хамгаалах зорилт нь зүйл, экологийн үйл явцыг удаан хугацаагаар оршин тогтоход шаардлагатай популяци, тэдгээрийн тархацыг хамгаалах эхний таамаг юм. Төлөөлүүлэн хамгаалах зорилтыг дасан зохицох менежментийн суурь, таамаглал гэж үзэх нь зүйтэй. Бид хамгаалах шаардлагатай газрыг сонгохдоо өнөөгийн болон ирээдүйд учирч болзошгүй аюул уршигийн нөлөөлөлд тэсвэрлэх чадварыг хангахын тулд хүрээлэн буй орчин, амьдрах орчны олон янз байдлыг хангалттай давтагдалтай байдлаар төлөөлүүлэхийг эрмэлзлээ. Төлөөлүүлэн хамгаалах зорилтыг талбайн хэмжээ ( $\text{км}^2$ ) ба экосистемийн хэв шинжээр ялган жагсаав (Хавсралт 1).

Бид хамгаалах шаардлагатай газрыг тогтоох болон сонгох явцад хамгааллын төлөөлөл зүйлийн тархацын загварчлалыг шууд ашиглаагүй болно. Хамгаалах шаардлагатай газар нутгийг тогтооход зүйлийн тархацын загварыг ашиглах тохиолдолд, хамгааллын төлөөлөл зүйл тус бүрээр төлөөлүүлэн хамгаалах зорилт дэвшүүлэх шаардлага тулгардаг тул хүндрэлтэй байдаг. Учир нь: 1) хамгааллын төлөөлөл зүйлийн тархацын загвар нь хязгаарлагдмал мэдлэг, мэдээлэл дээр тулгуурласан төдийгүй хээрийн судалгаагаар газар дээр нь шалгаагүй байдаг, 2) зүйлийн хувьд тодорхой зорилт тавихын тулд популяцийн амьдрах чадварын талаар сайн ойлголтой байх ёстой, 3) устаж байгаа болон ховордсон зүйлийн хувьд байгаль хамгааллын практик зорилт нь одоо оршин байгаа популяцийн тархацыг хамгаалах эсвэл нэмэгдүүлэхэд чиглэгддэг.

Өмнө өгүүлснээр, газар нутгийн 30 хувийг хамгаалах зорилтыг экосистем болон амьдрах орчны ерөнхий хэв шинжийн (ерөнхий шүүлтүүрийн бүрдэл хэсэг) хувьд хамгаалах зорилт болгон хэрэглэх нь түгээмэл. Монгол улсын газар нутгийн 30 хувийг хамгаалах зорилтыг устаж байгаа, устаж болзошгүй ховордлын зэрэглэлтэй зүйлийн тухайд хэрэглэх боломжгүй. Учир нь, эдгээр ховордлын зэрэглэлтэй зүйлийн тархацын талаарх




Мэдээлэл дутмаг бөгөөд ялангуяа, жижиг хөхтөн, мөлхөгчид, хоёр нутагтны талаарх мэдээлэл хомс байдаг. Зүйлийн тархацын загвар нь устаж байгаа, устаж болзошгүй зэрэглэлд хамрагдсан зүйлийн хамгийн сүүлчийн амьдрах орчныг тогтоох найдвартай мэдээлэл болж чадахгүйг анхаарна уу. Гэсэн хэдий ч, зүйлийн тархацын загвар нь тусгай хамгаалалтай газар нутаг болон хамгаалах шаардлагатай газарт зүйлийн

амьдрах орчин хэр зэрэг хамрагдсан болохыг тооцоолох, цаашдын судалгааны ажлын чиглэлийг тодорхойлох зэрэгт ач холбогдолтой. Ялангуяа, бөхөн, цагаан зээр, хар сүүлт зээр, аргаль, ирвэс зэрэг уудам орон зайд тархан амьдардаг зүйлийн тухайд чухал идээшил амьдрах орчин нь зөвхөн тусгай хамгаалалтай газар нутагт хамрагдсан амьдрах орчноор хязгаарлагддаггүй.

**Зураг 7:** Зүйл болон амьдрах орчны хамаарлын муруй: Амьдрах орчны талбай болон зүйлийн тоо хэмжээний хоорондын хамаарал (Dobson 1996).

## **Зүйлийн тоо ба амьдрах орчны талбайн хэмжээ**



## 2.4 НӨЛӨӨЛЛИЙН ИНДЕКС

Амьдралын орчны экологийн бүрэн бүтээн  
байдал буюу түүхэн эсвэл байгалийн  
нөхцөл байдлаас хэрхэн өөрчлөгдсөнийг  
илэрхийлэх шууд бус хэмжүүр нь  
хүний үйл ажиллагааны хуримтлагдах  
нөлөөлөл юм. Бид мэдээллийн олдоц  
дээр тулгуурлан хүний үйл ажиллагааны  
өнөөгийн нөлөөллийн хэлбэр, эх  
үүсвэрийг ГМС дээр тооцоолох замаар  
нөлөөллийн индексийг тооцоолсон.  
Боловсруулсан нөлөөллийн индексийг  
хамгаалах шаардлагатай газар нутаг

сонгоход экологийн харьцангуй сайн нөхцөлд оршиж байгаа экосистемийн хэв шинжийг хамруулахад ашигласан болно. Эдгээр бүрдэл хэсгийг дор тайлбарлав (Хүснэгт 4, Зураг 8 болон Зураг 9-ийг үзнэ үү).

- Хүн ам төвлөрсөн суурин газар ба түүний орчмын нөлөөнд өртсөн газар нутаг: Аймгийн төв, сумын төв, хилийн боомт орчмын газар нутаг нь ихэвчлэн бэлчээрийн талхигдал (Fernandez-

Gimenez 2001), ан агнуурын дарамтад өртсөн (Wingard and Zahler 2006) байхын зэрэгцээ зэрлэг амьтад нохойд хөөгдөх, ноцуулах нь (Young et al. 2012) түгээмэл тохиолддог.


- Автозамын сүлжээний нягтшил, ачаалал ба төмөр зам: Автозам нь зэрлэг амьтны амьдрах орчин, амьдралын хэв маягт олон хэлбэрээр сөрөг нөлөө үзүүлдэг (Trombulak and Frissell 2000). Судалгаанд хамрагдаж буй бус нутагт ихэнх автозам нь шороон зам бөгөөд байнга өөрчлөгдөж байдаг. Зарим замыг бусдаас илүү эрчимтэй ашигладаг тул нэлээд хэдэн замыг ачаалал ихтэй зам гэж тодорхойлсон. Бид автозамыг өмнө хэвлэгдсэн газрын зураг, Монгол орны автозамын атлас (Монсудар 2009)-ыг ашиглан тоон хэлбэрт оруулсан болно. Үүний үр дүнд хэдийгээр бүрэн бус боловч, байнга ашиглагддаг замыг ГМС-д орууллаа.
- Уул уурхай, түүнийг дагалдсан дэд бүтэц: Уул уурхай, түүнийг дагалдсан дэд бүтцийн нөлөөлөл нь тухайн газраар хязгаарлагдахгүй, ургамалшил, газар доорх усанд үзүүлэх нөлөөлөл (уурхайн нүх, дэд бүтэц гэх мэт) нь уудам орон зайд тархдаг. Уул уурхайн үйл ажиллагааны зориулалтаар гүний ус татсанаар тухайн газар нутгийн газрын гадаргад ойр газрын доорх усны түвшин доошилж, энэ үзэгдэл нь улмаар газрын доорх усны сүлжээнээс хамаарч илүү уудам газар нутгийг ч хамарч болно (Walton 2010). Тухайлбал, худаг, булаг шанд, ургамлын бүтээмжид нөлөөлж, ус тэжээлийн хангамжийг бууруулж, баянбүрд, хайлааст шугуй, заган төгөл зэрэг газрын доорх устай шүтэлцээтэй экосистемд нөлөөлдөг. Уул уурхайн үйл ажиллагаанд ашиглаж байгаа авто зам нь их хэмжээний тоос дэгдээх ба энэ нь алс тархаж, улмаар ургамлын бүтээмжийг бууруулдаг (Walton 2010). Тоосжилтын нөлөө, шилжилт

хөдөлгөөний талаар хийгдсэн маш олон судалгааны тухай сонирхож болно (<http://www.roaddustinstitute.org/>; <http://www.dirtandgravel.psu.edu/Research/research.html>).


- Мал бэлчээрлэлтийн эрчим: Малын бэлчээр ашиглалт нь ургамлын зүйлийн бүрдэл (Fernandez-Gimenez and Allen-Diaz 2001) болон зэрлэг амьтны амьдрах орчны хэвийн нөхцөл, чанарт нөлөөлдөг. Мал зэрэгцэн орших нь зэрлэг амьтанд өрсөлдөөн бий болгон тэднийг амьдрах орчноос нь шахаж (Wingard et al. 2011, Yoshihara et al. 2008, Campos-Arceiz et al. 2004), эсвэл зэрлэг амьтны сорчлон иддэг ургамлын зүйлийн тоог буруулах зэрэг сөрөг нөлөө учруулдаг (Gana Wingard хэвлүүлээгүй мэдээ). Olson нар (2011)-ын судалгаагаар, цагаан зээр нь малчин айл орчмын газар нутгаас зайлсхийх ба хот айлын бөөгнөрөл нь цагаан зээрийн шилжилт хөдөлгөөнд саад учруулж, идээшил бэлчээртээ хүрэх боломжийг хязгаарладаг нь тогтоогджээ. Мөн малчин өрхийн нягтшил их газар, ойр орчимд нь цагаан зээрийн хууль бус агнуур (Wingard and Zahler 2006), гэрийн тэжээвэр нохойд бариулах, ноцуулах нь илүү түгээмэл тохиолддог болохыг судлаачид (Young et al. 2011, Buuveibaatar et al. 2009) тогтоожээ.


Бид хамгаалах шаардлагатай газар нутгийг сонгох явцад нэг талаас нөлөөлөлд бага өртсөн, экологийн харьцангуй сайн нөхцөлд байгаа газрыг оновчтой сонгох, нөгөө талаас мал олноор бэлчээдэг эдийн засгийн хувьд ач холбогдолтой, өрсөлдөхүйц газраас зайлсхийх шаардлагыг харгалзан үзэх зорилгоор нөлөөллийн индексийг ашигласан юм. Иймд нөлөөллийн индексийг байгаль хамгаалах арга хэмжээ шаардагдах хөрөнгө оруулалттай холбогдолтой зардлыг тооцоолох ерөнхий арга гэж үзэж болох юм.

**Зураг 8:** Нөлөөллийн индексийн хүчин зүйлүүд ба ГМС-ийн мэдээллүүд. Нөлөөллийн индекс нь нөлөөллийн төрөл болон эх үүсвэрийг харуулсан ГМС-ийн мэдээллээр тооцоологдсон.



**Зураг 8:** Үргэлжлэл



**Зураг 9:** Нөлөөллийн индекс

**Хүснэгт 4:** Нөлөөллийн индексийн тооцоолол. Энэ хүснэгтэд нөлөөллийн хүчин зүйл, тухайн мэдээллийн эх сурвалж, ГМС-ийн хэмжилтийн үзүүлэлт болон нөлөөллийн индексийн харгалзах утгыг үзүүлэв.

## 1. Зам тээвэр

- Хатуу хучилттай зам (ГХГЗГ, 2014)  
5 км-ын радиус доторх нягтшил\*
- Улсын чанартай зам (хучилттай, хучилтгүй) болон төмөр зам  
5 км-ын радиус доторх нягтшил\*
- Бүх авто зам болон төмөр зам: хучилттай зам, улсын чанартай шороон зам, туслах замууд, бусад  
5 км-ын радиус доторх нягтшил\*
- индекс = а + б + в нийлбэр\*

## 2. Хүн амын төвлөрөл

- Хот, тосгон, бусад суурин газрууд (Газрын нэгдмэл сан, 2010)  
Нийлбэр (Эвклидийн зайн урвуу утга, 5 км-ийн радиус) + (5 км-ийн радиус дахь нягтшил)\*
- Бусад суурин газрууд (ГХГЗГ, 2014)  
Нийлбэр (Эвклидийн зайн урвуу утга, 5 км-ийн радиус) + (5 км-ийн радиус дахь нягтшил)\*
- Хилийн боомтууд  
Эвклидийн зайн урвуу утга, 10 км-ийн радиус\*  
Нөлөөллийн хэмжээ, байршлын хувьд тодорхой бус учир 10 км-ын радиус сонгосон



- г. Суурин газрын шөнийн гэрэлтэлт (NOAA, 2011)\*
- е. индекс =  $a, b, v, g$  хамгийн их утга\*

### 3. Уул уурхай

- Ашиглалтын тусгай зөвшөөрөл, уул уурхай ба газрын тос, 2014 оны 4-р сар (АМГ, 2014)
- а. Эвклидийн зайн урвуу утга, 5 км-ын радиус\*
  - б. 5 км радиус дахь нягтшил\*
  - в. индекс =  $a + b$ -н нийлбэр\*

### 4. Газар тариалан (ГХГЗГ, 2014)

- а. Өндөр эрчимтэй: тариалан, буудай, хүнсний ногоо  
Эвклидийн зайн урвуу утга, 5 км-ийн радиус\*
- б. Бүх газар тариалан: тариалан, буудай, хүнсний ногоо, хадлан  
Эвклидийн зайн урвуу утга, 5 км-ын радиус\*
- в. индекс =  $a + b$ -н нийлбэр\*

### 5. Малчин өрхийн байршил (БСТ, 2010)

Бид Бодлого судлалын төвийн цуглуулсан цэгэн мэдээллийг нэг малчин өрхийн байршлыг төлөөлөхүйц 450x450 м хэмжээтэй торлосон талбай бүхий растер мэдээ болгон хөрвүүлсэн. Зарим газарт (малчин өрхийн байршлын судалгааны мэдээ сайн хийгдсэн газар) хөрвүүлгийн алдааг багасгахын тулд дээр дурдсан талбайн хэмжээг сонгов.

- а. өвөлжөө, хаваржaa: 5 км-ын радиус доторх нягтшил\*
- б. зуслан, намаржaa: 10 км-ын радиус доторх нягтшил\*
- в. индекс =  $a + b$ -н нийлбэр\*

### 6. Хуримтлагдах нөлөөллийн индекс

- а. дээр дурдсан таван ялгаатай үзүүлэлтийн нийлбэр утга
- б. индекс = [а. таван үзүүлэлтийн нийлбэр утга], [2. Хүн амын нягтшил] болон [3. Уул уурхай]-н үзүүлэлтийн нийлбэр утга

\* дээрх ялгаатай үзүүлэлтүүдийг 0-ээс 1 хүртэл жигд утгатай байхаар тохируулга хийсэн.

## 2.5. ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЦ

Хамгаалал шаардлагатай газар нутгийг сонгох ГМС-ийн боловсруулалт, дүн шинжилгээ хийхийн тулд судалгааны бүс нутгийг ижил дүрс (зургаан өнцөгт) болон хэмжээтэй (50 км<sup>2</sup>) 7,192 төлөвлөлтийн нэгжид хуваав. Төлөвлөлтийн нэгж тус бүрээр дараах утгыг өгсөн. Үүнд:

- Улсын тусгай хамгаалалттай газар болон бусад экологийн хувьд чухал,

хамгаалах шаардлагатай газар нутгуудыг хамарсан төлөвлөлтийн нэгж (2.1 хэсгийг харна уу).

- Төлөвлөлтийн нэгж тус бүрт хамаарах нөлөөллийн индексийн нийлбэр утгыг тооцох.
- Экосистемийн хэв шинж бүрээр төлөвлөлтийн нэгжийн тоог (талбай буюу тоо) гаргах.





## 2.6. ХАМГААЛАХ ШААРДЛАГАТАЙ ГАЗАР НУТГИЙГ СОНГОХ


МАРКСАН нь байгаль орчны төлөвлөлт хийхэд зориулагдсан компьютерийн багц программ хангамж бөгөөд хамгаалах шаардлагатай газрыг тогтооход хэрэглэгчийн дэвшүүлсэн биологийн олон янз байдлын бүрдэл хэсгийг төлөөлөн хамгаалах зорилтыг хамгийн оновчтой хувилбараар сонгохын зэрэгцээ, хэрэглэгчийн тогтоосон төлөвлөлтийн нэгжийн өргтийн утга хамгийн бага байхаар сонгох боломж олгодог (Ball & Possingham, 2000; Possingham, Ball & Andelman, 2000). МАРКСАН-ы өргтийн функц нь амьдрах орчин хоорондын холбоосыг хангахын тулд хил залгаа зэргэлдээ орших амьдрах орчныг сонгох хувилбартай. Өргтийн функцийн талаар Possingham (2000), Game & Grantham (2008) нар бүтээлдээ дэлгэрэнгүй тайлбарласан байдаг тул эдгээр эх сурвалжаас лавлан үзэж болно.

Бидний дүн шинжилгээнд 7,192 ширхэг зургаан талт төлөвлөлтийн нэгжийг авч үзлээ. Биологийн олон янз байдлын бүрдэл хэсэг нь экосистемийн 99 хэв шинжээс бүрдэнэ. Төлөвлөлтийн нэгжийн өргтийг төлөвлөлтийн нэгж дэх нөлөөллийн индексийн нийлбэрээр тооцов. Улсын тусгай хамгаалалттай газар болон экологийн хувьд чухал, хамгаалах шаардлагатай газар нутаг (2.1 хэсгийг харна уу)-ийг шууд хамруулсан бөгөөд экосистемийг төлөөлүүлэн хамгаалах зорилтыг биелүүлэхийн тулд

төлөвлөлтийн нэгжийг нэмж өгөв. Үүний үндсэн дээр МАРКСАН программыг ашиглан экосистемийн төлөөлүүлэн хамгаалах зорилтод нийцсэн хамгаалах шаардлагатай газрыг тогтоосон юм (Зураг 10). Мөн экологийн хэвийн нөхцөлд байгаа (нөлөөний индексийг ашиглан) газрын сонголт, түүний үр дүнг сайжруулахын тулд төлөвлөлтийн нэгжийг аль болох нэгдмэл, хил залгаа зэргэлдээ байх шаардлагыг анхаарч үзэв.

Марксан программ нь ялгаатай хэдэн үзүүлэлтийг (биологийн олон янз байдал, хамгаалах хувь хэмжээ, нийлбэр утгын индекс, газрын хилийн урт, жингийн коэффициент зэрэг) харгалzan, боломжит олон хувилбарыг тооцоолдог ба үр дүнг нь "хамгийн шилдэг шийдэл" буюу "шийдлийн нийлбэр" болгон боловсруулдаг. МАРКСАН-ы сонголт бүр нь тусгай алгоритм ашиглан (нөлөөллийн индекст үндэслэн), төлөвлөлтийн нэгжийн өртөг ба хилийн урт хамгийн бага байх, зорилтод хамгийн бага зардлаар хүрэхээр тооцоолдог. "Хамгийн шилдэг шийдэл" гэдэг нь бусад сонголтоос хамгийн бага нийлбэр утгатай сонголт байdag. "Сонголтын нийлбэр" гэдэг нь олон удаагийн сонголтоор дахин давтагдан сонгогдож байгаа төлөвлөлтийн нэгжийн сонгогдох давтамжийн үзүүлэлт юм. Энэ хоёр үр дүн нь чухал бөгөөд нэмэлт давуу талуудтай юм. Тухайлбал, хамгийн шилдэг сонголт нь төлөөлүүлэн хамгаалах зорилтыг хангаж чадах, хамгийн үр дүнтэй төлөвлөлтийн нэгжийн сонголт, тэдгээрийн нийлбэр нь төлөвлөлтийн нэгж тус бүрийн сонголтод оруулах хамгийн үр дүнтэй хувь нэмрийг тооцох хэмжүүр болж байдагт оршино. Газар ашиглалтын байдал болон бусад мэдээлэл нэмэгдэхийн хэрээр хамгаалах шаардлагатай газар нутгийг шинэчлэн сайжруулж байх шаардлагатай тул сонголтын нийлбэр нь хамгаалах шаардлагатай газрын хувилбарыг тогтоох болон судалгаанд хамрагдсан газар нутгийн аль ч хэсгийн байгаль хамгааллын харьцангуй үнэ цэнийг тогтооход ашиглаж болох нэлээд ач холбогдолтой үзүүлэлт юм.

**Зураг 10:** Хамгаалах шаардлагатай газар нутгууд. Энэ зурагт хамгаалах шаардлагатай газар нутгийг сонгохдоо УТХГ, бусад экологийн үнэ цэнэтэй хамгаалах шаардлагатай газрууд болон бүх экосистемийн хэв шинжийн хувьд тархац 30 хүртэл хувь багтсан байхаар хамгийн зохистой нөхцөл байдал (нөлөөллийн индекс тус бүрээр - Бүлэг 2.4, Бүлэг 2.6) бүхий газар нутгуудыг хамруулсан болно.



## 2.7. СУДЛААЧДЫН ТОГТООСОН ХАМГААЛАХ ШААРДЛАГАТАЙ ГАЗАР НУТАГ

Ландшафтын түвшний хамгааллын төлөвлөлтөнд ГМС-ийн мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, хамгаалах шаардлагатай газар нутгийг тогтоох үйл явц нь суурь мэдээллийн нарийвчлал, баталгаатай байдал, газрын зургийн чанар зэргээс ихээхэн хамааралтай байдаг. Судалгаанд хамрагдсан Хангай, Хөвсгөлийн бус нутаг нь өргөн уудам газар нутгийг хамарч буй тул шийдвэр гаргахад ерөнхий мэдээлэл болох юм. Иймээс хамгаалах шаардлагатай газар нутгийг тогтоох ГМС-ийн дүн шинжилгээнд нэмэлт болох, чиглүүлэх, засан сайжруулахад судлаачдын санал, зөвлөмж, оролцоо туслалцаа зайлшгүй хэрэгтэй. Судлаачдаас бүрдсэн судалгааны зөвлөх баг

судалгааны эхний шат болох судалгааны бус нутаг тогтоох, ховор зүйлийн жагсаалт гаргах зэрэг үйл ажиллагаанаас эхлэн хамгаалах шаардлагатай газар нутгийг тогтоох эцсийн шат хүртэл ажилласан юм. Судалгааны зөвлөх баг 2015 оны 4-р сараас 11-р сар хүртэл хэд хэдэн удаа уулзалт хийж ГМС-ийн тусламжтайгаар боловсруулсан хамгаалах шаардлагатай газар нутгийг сонгосон байдлыг дүгнэн хэлэлцэв. Б.Оюунгэрэл, Д.Даш нар судалгааны бус нутгийн хүрээнд тухайн хамрагдаж буй орон нутгаас санал авах зорилгоор аймаг орон нутагт уулзалт хийж ажиллав. Энэ ажлын үр дүнд 9 газар нутгийг шинээр нэмж хамруулах санал боловсруулсан юм (Зураг 10, Хавсралт 3).



## 3.0 ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

### 3.1. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮНГ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ БА НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАХ НЬ

Энэ судалгаа нь уул уурхайн хөгжил, бэлчээрийн мал аж ахуй, зэрлэг амьтдын амьдрах орчныг хамгаалах шаардлагуудыг тэнцвэртэй хослуулсан газар зохион байгуулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөх боломж олгож байгаа юм. Мөн тусгай хамгаалалтай газрын сүлжээг өргөтгөх, тэдгээрийн менежменттэй холбоотой шийдвэр гаргах ба уул уурхайн хөгжлийн нөлөөллийг зохистой бууруулах бодлого болон практик үйл ажиллагааг дэмжих ач холбогдолтой.

#### 3.1.1 Тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээний өргөтгөл ба менежмент

Манай судалгааны үр дүнг Монгол улсын төрийн нийт нутаг дэвсгэрийн 30 хүртэлх хувийг хамгаалалтад авах зорилтыг биелүүлэх болон тусгай хамгаалалтай газрын менежментийг сайжруулах, ач холбогдолын эрэмбэ тогтоох зэрэг үйл ажиллагаанд ашиглаж болно. Улсын Их

Хурлын 13 тоот тогтоолд, дээр дурдсан 30 хувийг хамгаалах зорилтыг биелүүлэхэд, нийт нутаг дэвсгэрийн 15 орчим хувийг орон нутгийн тусгай хамгаалалтад авахаар заасан ажээ. Түүнчлэн, энэ судалгааны үр дүнг орон нутгийн тусгай хамгаалалттай газрын зохистой сүлжээг бүрдүүлэхэд ашиглах боломжтой юм. Газрын тухай хуулинд аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөлтийг 12 - 16 жил тутамд хийж байхаар заажээ (Газрын тухай хууль, 123 дугаар зүйл, 2002).

Их Нартын БНГ (Анх орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан сум), Тост уулын орон нутгийн хамгаалалттай газар (Өмнөговь аймгийн Гурвантэс сум) нутаг нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг шинээр байгуулах, түүний менежментийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий зөв жишиг загвар болж байна. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс “Монгол улсын Тусгай хамгаалалттай

нутгийн сүлжээг бэхжүүлэх нь” (UNDP SPAN- Strengthening of the Protected Area Network in Mongolia) төслийн хүрээнд Их Нартын БНГ-ыг үндэсний загвар гурван газар нутгийн нэгээр сонгон авч төсөл хэрэгжүүлж байна. Энэ төслийг БОАЖЯ- ны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар хэрэгжүүлж байгаа бөгөөд менежментийн үр дүнтэй байдал, санхүүгийн тогтвортой байдлыг дээшлүүлэх зорилготой юм (<http://www.undp.mn/snrm-span.html>).

### **3.1.2 Уул уурхай, эрчим хүчиний хөгжлийн нөлөөллийг бууруулах чиглэл**

Судалгааны үр дүнг ашигт малтмал, газрын тосны тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрийн нөлөөллийг бууруулахад чиглэсэн шийдвэр гаргах явцад ашиглах боломжтой. Нэгдүгээрт, уул уурхайн хөгжил эрчимтэй явагдаж буй өнөө үед хамгаалах шаардлагатай газрыг тогтоох нь төлөвлөж буй уул уурхайн хөгжил болон байгаль хамгааллын хооронд үүсч болзошгүй зөрчлийг “урьдчилан мэдээллэх” боломж

бүрдүүлнэ. Хоёрдугаарт, хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх арга ба энэ судалгааны үр дүн нь хөгжлийн нөлөөллийг бууруулах (нөлөөллөөс зайлсхийх эсвэл дүйцүүлэн хамгаалах гэх мэт) талаар шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэр гаргах үйл явцад дэмжлэг үзүүлнэ.

Бүх төрлийн хөгжлийн төсөл нь биологийн олон янз байдал бүрт нөлөө үзүүлэх эсэх нь тодорхой бус бөгөөд давхцал үүсч л байвал нөлөөтэй гэж дүгнэж болохгүй. Иймээс, аливаа хөгжлийн төслийн нөлөөллийг үнэлэхийн тулд биологийн олон янз байдлын бүрдэл хэсэг тус бүрээр ялган авч үзвэл зохицтой. Үүний тулд, хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдлын тархац болон хөгжлийн нөлөөллийн талаар илүү нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай. Бидний хийсэн ландшафтын түвшний төлөвлөлт буюу экологийн бус нутгийн үнэлгээ нь хаана зөрчил үүсч болзошгүй илрүүлэх, мөн хаана ямар нэмэлт судалгаа шаардлагатай болохыг тогтоох эхний алхам болно.



Хангай, Хөвсгөлийн судалгааны бүс нутагт хамгаалах шаардлагатай газар нутгийг бид өмнө хийж гүйцэтгэсэн хялганат хээрийн (TNC, 2011) ба говь (TNC, 2013)-ийн экологийн бүс нутгийн үнэлгээнээс өөр аргачлааар сонгосон юм. Энэ тайланд хамгаалах шаардлагатай газар болон хөгжлийн төлөвлөлт хоорондын давхцал болон эдгээр давхцалаас үүсэх зөрчлийг бууруулах зорилгоор хамгаалах шаардлагатай газар нутгийг “дахин шинэчлэн тогтоох” дүн шинжилгээг тусгаагүй болно. Хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх аргачлал нь байгаль хамгаалал болон хөгжлийн хооронд үүсэх зөрчлийг бууруулах замаар байгаль хамгаалах зорилтод хүрэх арга замыг эрэлхийлэн, аливаа хөгжлийн төсөл хөтөлбөр байгаль хамгаалах зорилтой нийцэж буй эсэхийг үнэлэх ландшафтын түвшний төлөвлөлт дээр үндэслэдэг.

Өмнө хийгдсэн экологийн бүс нутгийн үнэлгээний тайлангуудад хамгаалах шаардлагатай газар нутгийг тодорхойлсоны дараа сонгосон газруудад уул уурхайн тусгай зөвшөөрлийн давхцал үүсэж буй эсэхийг шалгасан байдаг. Эдгээр давхцалтай газарт экологийн хувьд чухал үнэ цэнэтэй, дахин сэргэн нөхөгдөх боломжгүй, хамгаалах шаардлагатай зарим газар нутгийг тодорхой хэдэн шалгуур үзүүлэлт дээр тулгуурлан, хөгжлийн төслийг хэрэгжүүлэхээс татгалзах газруудад оруулж ангилсан. Бусад үлдсэн давхцал бүхий зөрчилтэй газруудыг ижил төстэй амьдрах орчин, экологийн нөхцлийг тусгай зөвшөөрөлтэй талбайгаас гадна орших, нөлөөлөлд өртсөн амьдрах орчин бүхий газарт шилжүүлэн хамгаалах зорилгоор тогтоосон болно.

Хамгаалах шаардлагатай газар болон хөгжлийн төлөвлөлт хоорондын давхцал болон эдгээр давхцалаас үүсэх зөрчлийг бууруулах зорилгоор хамгаалах шаардлагатай газар нутгийг “дахин шинэчлэн тогтоох” дүн шинжилгээг тусгаагүй нь тус үнэлгээг тусгай

зөвшөөрөл олгох шийдвэрт чиглэл өгөх тал дээр ашиглахад хязгаарлагдмал буюу дутагдалтай байх магадлалтай юм. Хөгжил болон байгаль хамгааллын давхцал тус бүрийг анхааралтай шалгаагүй тохиолдолд хөгжлийн зорилгыг байгаль хамгааллаас илүүд үзэн, үр дүнг хэрэгсэхгүй болгох муу талтай (Clare et al., 2011). Ихэнх нөлөөлөл бууруулах тогтолцоо нь нөлөөлөл бууруулах дарааллын хамгийн чухал алхам болох нөлөөллөөс зайлсхийх үйл явцыг ихэнх тохиолдолд хэрэгжүүлэлгүй орхигдуулдаг тал дээр эрдэмтэн, судлаачид болон бодлого боловсруулагч нар санал нийлдэг (Villaroya et al., 2013). Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох тогтолцоо нь нөхөн сэргээгдэх боломжгүй, орлуулах боломжгүй биологийн олон янз байдлын бүрдэл хэсэгт үзүүлэх нөлөөллөөс зайлсхийх алхамыг зайлшгүй хэрэгжүүлэхээр хуульчлах нь зүйтэй (Kiesecker et al., 2010, Villaroya et al., 2013). Ялангуяа, ховор, буюу устах аюулд орсон зүйлүүдийг хамгаалахад анхаарлаа хандуулах ёстой (Regnery et al., 2013). Энэ асуудлыг хэрэгжүүлэхэд Kiesecker et al., (2010)-ийн АНУ-д, TNC болон БОНХЯ (2011, 2013)-ны Монгол улсад хийж гүйцэтгэсэн нөхөн сэргээгдэх боломжгүй болон эмзэг байдлын шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан шинжлэх ухаанд суурилсан ландшафтын түвшний системтэй байгаль хамгааллын төлөвлөлтийн дагуу үнэлгээ хийх шаардлагатай.

### **3.1.3 Зээлдүүлэгчийн гүйцэтгэлийн стандарт: чухал амьдрах орчин**

Монгол улсад хэрэгжиж буй зарим шинэ хөгжлийн төсөл хөтөлбөрүүд нь Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ, 2008), Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК, 2012) зэрэг санхүүгийн байгууллагаас санхүүжилт авч байгаа юм. Эдгээр зээлдүүлэгч байгууллагууд нь шинээр батлагдсан гүйцэтгэлийн стандарт, шаардлага, зөвлөмжийг дагаж мөрддөг (ОУСК, 2012). Гүйцэтгэлийн стандартын

зорилго нь хөгжлийн төслийг тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дэмждэг, биологийн олон янз байдлыг хамгаалах, байгалийн амьд нөөц баялгийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглүүлдэг. Хангай, Хөвсгөлийн экологийн бус нутгийн үнэлгээний ажлын үр дүнг гүйцэтгэлийн шинэ стандартыг (ОУСК, 2012) хэрэгжүүлэхэд хэрхэн ашиглах тухай доор тайлбарласан болно. Гүйцэтгэлийн стандарт 6-г хэрэгжүүлэх зорилгоор амьдрах орчныг 'өөрчлөгдсөн', 'байгалийн хэвийн', 'чухал' хэмээн хувааж үзлээ.

'Чухал' амьдрах орчинд дэлхийн эсвэл үндэсний хэмжээнд устаж байгаа ба устаж болзошгүй, хязгаарлагдмал тархацтай эсвэл унаган зүйл, нүүдлийн ба олноор цугладаг зүйлийн бөөгнөрөл бүхий, хөнөөлд хэт өртсөн ба өвөрмөц жижиг экосистем, эволюцийн чухал үйл явцыг агуулсан газар нутаг багтана. Эдгээр газруудыг хамгаалах шаардлагатай газар нутагт оруулсан тул чухал амьдрах орчиньг тогтооход ашиглах боломжтой. Өөрөөр хэлбэл, хамгаалах шаардлагатай газар нутгуудыг чухал амьдрах орчин гэж үзэж болох тул эдгээр газруудад нөлөөллөөс зайлсхийх шаардлагатай.


Бид хамгаалах шаардлагатай газар нутгийн эхний хувилбарыг боловсруулах үе шатанд ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй давхцаж буй хэсгийг боломжтой бол өөр ижил хэв шинж бүхий газрыг судалгааны бүсийн хэмжээнд олж тогтоож болох тухай өмнө дурдсан. Давхцлын улмаас хамгаалах шаардлагатай газар нутгийн жагсаалтаас хасагдсан эдгээр газруудыг ч мөн чухал амьдрах орчин гэж үзэх нь зүйтэй. Дурдсан газарт хөгжлийн үйл ажиллагаа хэрэгжих тохиолдолд биологийн олон янз байдлын хувьд эерэг үр дүнд хүрэхийн тулд үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах ёстой. Хамгаалах шаардлагатай газар нутгийн гадна байх байгалийн ургамалшил бүхий газар нутгийг 'байгалийн хэвийн' амьдрах орчин гэж үзнэ. Хөгжлийн төсөл энэ газарт хэрэгжиж болох боловч биологийн

олон янз байдлын хувьд алдагдалгүй байх зорилгоор үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах ёстой гэж үздэг.

### **3.1.4 Дүйцүүлэн хамгаалах газрыг тогтоох нь**

Хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх ба нөлөөллийг бууруулах үе шатны дараагийн алхам нь төслийн нөлөөллийн цар хүрээг тодорхойлж, дүйцүүлэн хамгаалах хамгийн боломжтой, зохистой хувилбарыг тогтоох үйл явц юм. Хөгжлийн төслийг хэрэгжүүлэхэд аль болох олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн менежментийн шилдэг практикийг хэрэгжүүлэх замаар төслийн нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой. Байгаль хамгаалал ба хөгжлийн хэрэгцээний тэнцвэрийг хангахын тулд хөгжлийн нөлөөллөөс зайлсхийх, бууруулах/нөхөн сэргээх үе шатыг зохих ёсоор хэрэгжүүлсний дараа үлдэгдэл нөлөөллийг тооцож, түүнийг дүйцүүлэн хамгаалах нь зүйтэй. Хөгжлийн төсөл хэрэгжүүлж буй газар биологийн олон янз байдлын хувьд алдагдалгүй байх зорилт дэвшиүүлэх нь хамгаалах шаардлагатай газрын гадна бий болж буй нөлөөллийг хамгаалах шаардлагатай газарт хэрэгжих байгаль хамгаалах үйл ажиллагаа болгон хувиргах (дүйцүүлэн хамгаалах) замаар байгаль хамгааллын зорилтод хүрэх боломж бүрдэнэ.

Дүйцүүлэн хамгаалал нь нөлөөлөлд өртсөн газартай экологийн хувьд ижил төстэй, үр дүнд хүрэх, аль болох нөлөөлөлд өртсөн газартай ойр байх, ландшафтын түвшинд байгаль хамгаалах зорилтыг биелүүлэх зарчмыг удирдлага болгодог. Дүйцүүлэн хамгаалах газрыг тогтооход төслийн нөлөөлөлд өртсөн газартай экологийн нөхцөл ижил төстэй, дүйцэхүйц байх, ойр зэргэлдээ орших зэрэг шалгуурыг хэрэгжүүлэхэд хамгаалах шаардлагатай газар нутгийг ашиглаж болно. Хамгаалалтад авах шаардлагатай газрыг ландшафтын түвшний байгаль хамгаалах зорилтод хүрэхийн тулд дүйцүүлэн хамгаалах газрыг нэгэнт тогтоогдсон



хамгаалах шаардлагатай газраас сонгох нь ландшафтын түвшний байгаль хамгаалах зорилгод нийцнэ. Дүйцүүлэн хамгаалах зорилгоор хэрэгжүүлж буй байгаль хамгаалах үйл ажиллагааг үнэлэхийн тулд хамгааллын ач холбогдол, эрсдэл, өргтийг тооцож үнэлэх нь чухал (McKenney & Kiesecker 2010, Kiesecker et al.).

### 3.1.5 Газар ашиглалтын төлөвлөлт

Хамгаалах шаардлагатай газар нутаг, түүнтэй холбоотой мэдээллийг улс, аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөлт, бүсчлэлийг тогтооход ашиглах боломжтой. Амьдрах орчин, малчин айл өрхийн нягтийл, газар ашиглалтын бусад зургуудыг бэлчээрийн нөөц газрыг тогтоох, зохистой ашиглах, зэрлэг амьтан ба мал хоорондын бэлчээрийн өрсөлдөөнийг бууруулах, бэлчээрийг зохистой ашиглах, зохицуулах зэрэг бэлчээрийн менежментэд ашиглаж болно. Хээрийн бүсэд орших хамгаалах шаардлагатай газар нутгийг ган, зуд зэрэг байгалийн гамшигт үзэгдэл, эсвэл онцгой тохиолдоос бусад үед малын бэлчээр, хадлан тэжээл бэлтгэх үйл ажиллагаанаас чөлөөлж, бэлчээрийн нөөц газар (отрын бэлчээр) хэлбэрээр ашиглах

боломжтой. Өмнөговь аймагт хийсэн Leisher et al. (2010) нарын судалгаагаар, малчдын оролцоотой менежмент бүхий бэлчээрийн нөөц газар нь хэрэв зохистой ашиглаж чадах аваас цаг хүндэрсэн үеийн бэлчээр эсвэл отрын нөөц бэлчээр болох зэрэг ашиг тустай нь тогтоогджээ. Бэлчээрийн хэв шинж, ургац, бүтээмж, газар ашиглалт дээр тулгуурлан бэлчээрийн нөөц газрыг тогтооход хамгаалах шаардлагатай газар нутгийг ашиглах боломж бас бий. Бүс нутгийн ГМС-ийн мэдээллийг уул уурхай, түүнийг дагалдах дэд бүтцийн хөгжлийн үйл ажиллагаанаас бэлчээрт үзүүлэх нөлөөллийг тогтоох, мөн уул уурхайн хөгжил зэрэг газар ашиглалтын өөрчлөлттэй уялдан нутгийн иргэд, мал сургийг нүүлгэх, төлөвлөхөд ашиглаж болно.

Экосистемийн орон зайн загварт голын татам, ус намгархаг газрыг Монгол орны хэмжээнд бид зурагласан. Энэ нь Монгол улсын “Усны тухай хууль”-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах гол мөрний хамгаалалтын бүсийг тодорхойлох суурь мэдээлэл болсон юм (Усны тухай хууль, 2007). Уг судалгааны талаарх



санал зөвлөмж, дэлгэрэнгүй мэдээллийг ДБХС-аас БОНХАЖЯ-д боловсруулж хүлээлгэн өгсөн тайлангаас харна уу (WWF Mongolia and TNC Mongolia, 2014). Орон зайн загварын үр дүнг өнөөгийн байдлаар орон нутгийн газар ашиглалт, байгаль хамгааллын төлөвлөлтөд хэрхэн ашиглагдах талаар таарцыг хянан шалгах ба засаж сайжруулах ажил хийгдэж байгаа юм (WWF Mongolia, 2015).

### 3.1.6 Суурь судалгааны үндэслэл болох нь

Монгол орны угуул ургамал, амьтны түүхэн тархац хадгалагдан үлдсэн боловч, зарим зүйл нь ховордоод байгаа билээ. Цаашид ашигт малтмалын олборлолт, түүнийг дагасан дэд бүтцийн хөгжлийн нөлөөгөөр уlam бүр ховордож болзошгүй. Судалгаанд хамрагдсан бус нутгийн дийлэнх нь бага судлагдсан бөгөөд устаж болзошгүй, ховордсон амьтан, ургамлын зүйлийн өнөөгийн төлөв байдал, экологийн талаар мэдээлэл хомс байна. Байгаль хамгааллын үйл


ажиллагаа, нөлөөллийг бууруулах, мониторинг хийхэд шаардагдах үндсэн судалгаа, шинжилгээний ажлыг яаралтай эхлүүлэх хэрэгтэй байна (Batsaikhan et al. 2010, Clark et. al 2006). Зарим алслагдмал нутагт хийсэн судалгаагаар өмнө нь ажиглагдаж байгаагүй шинэ зүйл олонтой тэмдэглэгдэж байна. Ургамалшил, экосистемийн зураг ба зүйлийн тархацын загварыг зүйлийн эсвэл ургамалшлын судалгааны ажлыг төлөвлөх, чиглүүлэхэд ашиглаж болно. Ирээдүйд ийм чиглэлийн судалгаа хийснээр ургамалшил, экосистемийн зураг ба зүйлийн тархацын загварыг сайжруулах боломж бүрдэнэ.

## 3.2. БУСАД ЗӨРЧИЛТ АСУУДЛУУД

### 3.2.1 Хамгаалах шаардлагатай газар нутаг ба тусгай зөвшөөрөл давхцсан газар нутаг

Хамгаалах шаардлагатай газартай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий 49 талбай давхцасан байна (Зураг 11).

**Зураг 11:** Хамгаалах шаардлагатай газар болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй давхцал үүсч буй газрууд





### **3.2.2 Зэрлэг амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах саад бэрхшээл**

Судалгааны бүсэд хамраарах олон ялгаатай экосистем нь уудам нутагт тархан амьдрах олон зүйл амьтны тархац, идээшил нутгийг тэтгэж байдаг. Үүнд үудам газар нутагт тархан амьдардаг хөхтөн амьтны зүйл: уулын туурайтан янгир, нэн ховордсон аргаль, мах идэшт амьтны зүйлээс нэн ховордсон ирвэс зэрэг зүйлийг дурдаж болно. Эдгээр зүйл амьтад нь идэш тэжээлийн хомс нөөцөөс хүртэх, үржилд орох замаар генийн сангаа хадгалах зэрэг мэнд үлдэж орших үндсэн шаардлагын улмаас уудам газарт шилжих нүүдэллэх хэрэгтэй болдог. Одоо оршин байгаа болон ирээдүйд бүтээн байгуулахаар төлөвлөж байгаа зам тээврийн дэд бүтэц бол амьтдын шилжилт хөдөлгөөн, нүүдэлд учруулах үндсэн саад бэрхшээл болж байна (Batsaikhan et al. 2014; Ito et al., 2005; Ito et al., 2013; Kaczensky et al. 2006, Olson 2012, Lkhagvasuren et al. 2011). Эдгээр шилжилт хөдөлгөөнд учруулах саад тогторыг үр дүнтэй бууруулах нь өргөн уудам газарт тархан, идээшин амьдардаг зэрлэг амьтдын урт хугацаанд оршин амьдрахад нэн чухал бөгөөд Lkhagvasuren et al. (2011); Olson (2012); Huijser et al. (2013);

Wingard et al. (2014) CMS (2015a, 2015b) нарын судлаачид судалгаа шинжилгээ, хамгааллын ажлын гол сэдэв болгон хөнджээ.

Зэрлэг амьтны нүүдэл, шилжилт хөдөлгөөнд чухал газрыг хамгаалах нэг загвар жишээ бол, АНУ-ын өрнөд нутагт Холбооны болон муж улсын засгийн газар, төрийн бус байгууллага, газар өмчлөгчид хамтран байгуулсан цав эвэрт (*Antilocapra americana*) гөрөөсний нүүдлийн зурvas нутаг юм. Энэ зурvas нутаг нь газрын тос, байгалийн хий олборлолт, тэдгээртэй холбоотой хурдацтай баригдаж буй дэд бүтэц зам, төрон хааша болоод хувийн болон нийтийн эзэмшлийн газрыг хамарчээ. Дурдсан зурvas газрын хамгаалалт ёсоор Холбооны болон муж улсын Засгийн газрын мэдлийн газарт баригдах дэд бүтцийн барилга байгууламж, төлөвлөлт нь цав эвэрт гөрөөсний нүүдлийн замналын шаардлагыг хангах ёстой ажээ (USFS 2008).

### **3.2.3 Голын татам, ус намгархаг газрыг хамгаалах нь**

Газрын зурагт дүрсэлсэн экосистемийн ангилалд зэрлэг амьтан, мал, хүн амын суурьшлын тухайд биологийн үнэ цэнэ ихтэй ус намгархаг газар, газрын доорх



- 4.6.3 Голын хайрга, сайр орчмын ургамал Голын татмын ургамлын бүлгэмдэл нь экологийн бус нутаг бүрт харилцан адилгүй ажээ. Маньбазар (2015) өөрийн судалгаагаар Завхан, Ховд, Тэс, Идэр, Эг, Дэлгэрмөрөн, Сэлэнгэ зэрэг томоохон голын хөндийн үндсэн ялгааг дараах байдлаар тайлбарлажээ.
- Завхан гол, түүний цутгалуудын татмын хэв шинж**
- Харгана-боролжит (*Caragana jubata-Betula rotundifolia*) хэв шинжийн татам. 2500 м-ээс дээш өндөрлөг газар оршино. Тэнд нугат намгийн хүлэрлэг нимгэн хөрс голын эхийн асга, чулууны завсар зайгаар хэсэг бусгаар дайралдана. Ногоон ба хүлрийн хөвд ихтэй, өндөр уулын нугын алаг өвснөөс *Lagotis integrifolia* (Willd.) Schick., *Saxifraga nirculus* L., *Trollius asiaticus* L., *Polygonum viviparum*, *Aconitum baicalense*, *Polemonium coeruleum*, *Gentiana algida*, *Festuca altaica*, *Ptilagrotis mongholica*, *Kobresia bellardii*, *Dasiphora fruticosa*, *Salix berberifolia*, *S. numullaria* Anders., *S. myrtilloides* элбэг тохиолдоно.

2. Харгана-алаг өвст (*Caragana jubata-Geranium pretense*) хэв шинжийн татам. Буянт голд д.т.д. 2300-2800 м, Рашаант голд д.т.д. 2100-2500 м өндөрт элс шавранцар хурдаар хучигдсан асга чулуун чулуун суурь дээр голлож дайралдана. Голлох эвшил нь сөөгөн боролзгоно бүхий харгана, нугын алаг өвс (*Geranium pretense*, *Sanguisorba officinalis*, *Galium verum*, *Aconitum baicalense*) юм.
3. Шинэст (*Larix*) хэв шинжийн татам. Ийм татам Завхан голын хөндийд явцуу илэрнэ. Энэ татамд арц (*Juniperus pseudosabina*) алаг цоог толбо маягаар тохиолдож, улиастай (*Populus suaveolens*) холилдож ургана.
4. Улиас-боролзгонот (*Populus suaveolens-Dasiphora fruitcosa*) хэв шинжийн татам. Энэ хэв шинжийн татам Буянт голын хөндийд д.т.д. 1900-2300 м, Богдын голд д.т.д. 1700-2000 м өндөрт тус тус тархдаг. Голын хөвөө дагаж алаг өвс бүхий (*Salix divaricata Pall.* *S. caesia*) бургас, чачаргана (*Hippophae rhamnoides*) нарийн зурvas үүсгэж ургадаг. Богдын голын хөвөө тэмээн харгана (*Caragana spinosa*)-улиасан шугуйт татамтай.
5. Улиаст-цөлжүү (*Populus suaveolens-Allium polystachys*) хэв шинжийн татам. Завхан голын дунд биеэр 1700-1500 м өндөрт тохиолдоно. Тэмээн харгана, Чацаргана бүхий Улиас болон алаг өвстэй Бургас нь голын ба хөрсний доорх усанд голын татам дагаж цөлийн хээр рүү түрэн ордог.
6. Бургас нугат цөлөрхөг (*Salix-Allium polystachys*) хэв шинжийн татам. Завхан голын хөндийд д.т.д. 1400-1500 м өндөрт тохиолдоно. Өвслөг ургамлын ташингын зуршмал *Geranium pretense*, *Melilotus suaveolens*, *Iris lactea*, *Cirsium esculentum* зэрэг ургамлын оролцоо нэмэгднэ.
7. Давсжсан нуга (*Halerpestes salsuginosa*) хэв шинжийн татам. Завхан голын

адгаар 1400 м ба түүнээс доош өндөрт тохиолдоно. Татам дагуу давсжсан нугын хиаг (*Elymus chinensis-Suaeda rorriculata*), *Halerpestes salsuginosa-Suaeda corniculata* голлож голдрил орчмоор *Salix ledebouriana* ургадаг.

#### Тэс голын татмын хэв шинж

1. Шинэс-гнцүүрт (*Larix-Picea*) хэв шинжийн татам. Энэ татам д.т.д. 1100-1700 м үнэмлэхүй өндөрт тохиолдоно. Уг хэв шинжийн татмын эхээр ногоон хөвд бүхий шинэс (хөвдийн бүрхэц 30-70%, өвслөг ургамлынх 5-10% буюу түүнээс бага) голлож, бараа болох эвшилд *Caragana spinosa*, *Kobresia bellardii*, *Ptilagrotis mongholica*, *Carex pediformis* оролцсдог. Татмын дунд хэсэгт улалжтай гацуур зонхиlj, өвслөг ургамалд *Carex pediformis*, *Cobresia bellardii* оролцно. Татмын адгаар нь ойн *Equisetum arvense*, *Pyrola rotundifolia* ургасан хус, харгана бүхий бургастай гацуур голлон тохиолдоно.
2. Улиаст цөлжүү (*Populus suaveolens – Allium polystachys*) хэв шинжийн татам. Тэс голд д.т.д 800-900 метрийн өндөрт тохиолдоно. Татмыг захлан тохиолдох хужир, марзлаг газраар хармаг, таана зэрэг цөлжүү хээрийн ургамал үзэгдэнэ. Голын голдрилыг хөвөөлөн зурvas бургас, улиасны шугуй бий завсрын шинжтэй алаг өвс-Хиагт нуга *Vicia cracca*, *Lathyrus pratensis*, *Thalictrum simplex*, *Medicago falcata* зэрэг ургамал арви ихтэйгээрээ онцлог.

Монгол орны өрнөд хэсгийн татамд нийтлэг шинжтэй, чухал үүрэг гүйцэтгэдэг сөөг нь тэмээн харгана (*Caragana spinosa*), хус (*Betula spp.*) юм. Мөн гацуур (*Picea obovata*), дэрс (*Achnatherum splendens*), марцны гэц (*Halerpestes salsuginosa*), анхилуун улиас (*Populus suaveolens*) оролцсон эвшил үүсгэдэг. Харин хус (*Betula spp.*) түр зуурын хаялгатай нугархаг газрын давсархагдуу хөрсийг дагаж ургана.

## Идэр голын татмын ургамалшлын хэв шинж

Идэр болон Сэлэнгэ голын хөвөөний хурдас маш элсжсан байдаг. Идэр гол голдрилын налуугаар Хангайн бүс нутгийн бусад голоос ялгардаг. Шинэсэн ой (*Larix sibirica*) д.т.д 1450 м өндөрлөг газар тохиолдоно. Далайн түвшнээс дээш 1300 м-ээс доош намсах тутам бусад өндөр уулын түгээмэл ургамлын зүйл тухайлбал *Kobresia bellardii* ургадаг. Түүнчлэн *Carex enervis*, *Caragana jibata*, *Cirsium esculentum*, *Hordeum brevisubulatum* зэрэг зүйл өндөршил буурах тусам тохиолдох нь элбэг.

### 1. Торлогт хэв шинжийн татам

Энэ татам нь д.т.д 2400-2500 м өндөрт маш гүн голидоролтой байдаг ба *Betula rotundifolia*, *Spirea alpina*, *Betula fruicosa*, *Kobresia bellardii* зэрэг зүйл ургамлын оролцоотой. Ургамлын хувьд нугын болон хээрийн зүйл болох *Dasiphora fruticosa* болон *Aconitum baicalense*, *A. anthora* зүйл холилдон зонхилен.

### 2. Бургас-бушилзат хэв шинжийн татам

- Бушилз-боролзгонот татам. Энэ төрлийн татмын дэнж нь д.т.д 2300-2700 м өндөрлөг нөхцөлд оршдог. Шивэлз-бушилзат бүлгэмдэлд *Dasiphora fruitcosa*, *Betula frusicosa*, *Carex dichroa* зэрэг зүйл оролцно.
- Харгана-боролзгонот татам. 2000-2200 м өндөрт бут сөөгний зүйл болох *Dasiphora fruitcosa*, *Betula fruticosa*, *Caragana jubata*, *Salix sp.*, *Kobresia bellardii*, *Ptilagrotis mongholica*, *Thalictrum alpinum*, *Carex orbicularis*, *C. stenocarpa*, *Aconitum baicalense*, *Hordeum brevisubulatum*, *Carex enervis*, *Cirsium esculentum* зэрэг зүйлүүд тааралддаг.
- Шинэс-бушилзат татам. 1400-2100 м өндөрлөг газар саланги тусгаар оршдог.

### 3. Бургас-боролзгонот хэв шинжийн татам.

- Цахилдагт хувилбар. Энэ хэв шинж д.т.д 1200-1700 м өндөрт элсжин хурдас, элссэг нугын татамд *Iris lactea* зонхицдог ба мөн *Leymus chinensis*, *Heteropappus hispidus-Poa attenuata*, *Koeleria cristata*, *Potentilla bifurca*, *Dontostemon integrifolius*, *Chamaerhodos erecta* зэрэг хуурай цахилдагийн бүлдэмдлийн зүйлүүд тархдаг.

### 4. Улиаст хэв шинжийн татам.

Энэ хэв шинж д.т.д 1100-1200 м өндөрт Идэр голын адагт оршдог. Холимог улиасан шугуйд *Geranium pretense*, *Trifolium lupinaster* болон *Artemisia dracunculus*, *Erodium stephanianum*, *Thalictrum minus*, *Thermopsis lanceolate* зэрэг зүйл өвслөг ургамлын бүрхэвчтэй.

## Дэлгэрмөрөн голын татмын ургамлын хэв шинж

Өргөн тархацтай *Rhododendron parvifolium*, *Caragana jubata* ба *Betula rotundifolium* зэрэг мод, сөөг ургадаг.

1. Тэрэлж-торлогт хэв шинжийн татам. Далайн түвшнээс дээш 2100-2300 м өндөрт *Caragana jubata*, *Rhododendron parvifolium*, *Betula rotundifolia*, *Festuca altaca*, *Salix berberidolia*, *Kobresia Bellardii*, *Ptilagrotis mongolica*, *Gentiana algida*, *Thalictrum alpinum*, *Carex norvegica* зэрэг зүйл тохиолдоно.
2. Бургас-бушилзат хэв шинжийн татам. Далайн түвшнээс дээш 1900-2000 м өндөрт *Caragana jubata*, *Rhododendron parvifolium* зэрэг сөөг зонхицдог ба мөн *Kobresia bellardii*, *Ptilagrotis mongolica*, *Carex enervis*, *Cirsium esculentum*, *Triglochin palustris*, *Hordeum brevisubulatum*, *Glaux maritima*, *Dasiphora fruitcosa* зэрэг өвслөг болон сөөг ургамлын зүйл оролцдог.
3. Бургас-боролзгонот хэв шинжийн татам.

4. Улиас боролзгонот хэв шинжийн татам. Энэ хэв шинжид *Salix schverini*, *S. miyabeana*, *S. ledebouriana* зонхилдог.
5. Бургас-нугын хэв шинжийн татам. Далайн түвшнээс дээш 1100-1400 м өндөрт *Iris lactea*, *Elymus dahuricus*, *Artemisia laciniata*, *Bupleurum bicaule* зэрэг зүйл зонхилдог.

### **Эгийн голын татмын ургамлын хэв шинж**

900-1600 м өндөрт голын адаг орчим газраар модлог ургамалтай (*Larix sibirica*, *Populus suaveolens*, *Salix miyabeana*, *S.schverinii*, *Dasiphora fruitcosa*, *Ulmus pumila*) мөн *Rosa acicularis*, *Cornus alba*, *Grataegus samguinea*, *Ribes diacantha*, *R. rubrum*, *Malus pallasiana*, *Padus asitica*, *Cotoneaster melanocarpa* тааралддаг.

1. Бургас-бушилзат хэв шинжийн татам. 1200-1600 м өндөрт нам уулын *Salix schverinii* болон *Salix miyabeana* зонхилдог.
2. Шинэс-бушилзат хэв шинжийн татам. 1000-1200 м өндөрт *Trollius asiaticus*, *Carex vesicata* зонхилдог.
3. Улиас-боролзгонот хэв шинжийн татам. 100-900 м өндөрт *Populus suaveolens*, *Larix sibirica* зохилогчтой.

### **Сэлэнгэ мөрөний ургамлын хэв шинж**

Зохилох ургамлын зүйлд *Stipa sibirica*, *Artemisia dracunculus*, *Galium verum*, *Ulmus pumila*, *Echinops dahurica*, *Salix miyabeana*, *S. schverinii*, *Agropyron repens*, *Bromus inermis*, *Calamagrotis epigeios*, *Bromus inermis*, *Leymus chinensis*, *Iris lactea*, *Achnatherum splendens*.

### **Жижиг гол, горхи, булгийн татам**

ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ: Өндрийн тоон загвараас боловсруулан зурагласан жижиг хэмжээний гол, горхи, булгийн татам (голын эрэмбэ багатай, ус хураах талбай багатай).

Hilbig (1995)-ийн ялгасан ургамалшлын хэв шинжид:

- 4.4.1 Чийгсэг өндөр алаг өвст ургамшил (2)

---

### **Тарамцааг элс**

Уудам газар нутагт сунаж тогтсон тарамцааг элстэй газрыг 1:200,000 масштабтай байрзүйн зургаас тоон хэлбэрт шилжүүлэн зурагласан. Тарамцааг элсний усны сүлжээ нь өвөрмөц бөгөөд ургамлын ялгаатай бүлгэмдэл, зүйлийн олон янз байдлаар нэн баялаг, чийглэг нугажуу амьдрах орчинг бүрдүүлдэг. Эдгээр нь Их нууруудын хоттор, Олон нуурын хөндий (8% тархацтай) болон Хангайн экологийн бус нутгийн өрнөд этгээдэд гол төлөв тохиолдоно.

Востокова, Гунин (2005) нарын экосистемийн ангилалд:

21. Элсэрхэг хүрэн хөрстэй газар элссэг алаг өвс-үетэнт хээр шарилж (*Artemisia*), харгана (*Caragana*), буйлс (*Amygdalus*) сөөтг бүлгэмдэл
24. Хүрэн шавранцар ба элсэрхэг хөрстэй газар харгана (*Caragana*)-ны оролцоотой элссэг алаг өвс-дэгнүүлт үетэнт хээр
27. Цайвар хүрэн элсэрхэг-шавранцар ба элсэрхэг хөрстэй газар элссэг дэгнүүлт үетэн (*Agropyron*, *Stipa glareosa* and *S. gobica*, *Cleistogenes*)-т хээр ялгасажээ.

Hilbig (1995)-ийн ялгасан ургамалшлын хэв шинжид:

- 4.5.4 Элсэрхэг хээр
- 4.7.3 Элсэрхэг хөрстэй газрын хээржүү цэл (2)
  - 4.7.3.1. Суль (*Psammochloa villosa*)-т бүлгэмдэл
  - 4.7.3.2. Хөх тариархуу цагаан суль (*Elymus secalinus*)-т бүлгэмдэл

Х.Буян-Орших (1978) томоохон тарамцааг элснүүдийн ургамлын хэв шинжийг дараах байдлаар тодорхойлжээ:

## Хар бор элс

Энэ үлэмж элс Хангайн нуруун салбар уулсаас эхлэн Хүнгүй голын сав дагуу сунаж, Завхан голын аdag, Хяргас нуур хүрнэ. Хар бор элсэнд бунгийн харгана (*Caragana bungei*), крыловын хялгана (*Stipa krylovii*), мөн хуурайсаг дэгнүүлт үетэн дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa*) ургамлын нөмрөгт зонхилж, муу ширэгжсэн, нүцгэн манхан ихтэй учир жинхэнэ элссэг заримдаг сөөг, үндэслэг ишт үетэн *Artemisia xanthochroa*, *A. sphaerocephala*, *Hedysarum mongolicum*, *Psammochloa villosa* зэрэг Төв Азийн элсэн цэлийн гол төлөөлөгчид зонхилон бүлгэмдэл үүсгэдэг. *Elymus giganteus*, *Pugionum pterocarpum*, *Agrophyllum pungens*, *Corispermum declinatum* мэт элссэг ургамал алаг цоог ургана.

Харгана-хялгана-хазаар өвст хээрт *Cleistogenes squarrosa*, *Stipa krylovii* хуурайсаг дэгнүүлт үетэн болон *Caragana bungei* зонхилон бүлгэмдэл

үүсгэдэг. Элсний зах, хөвөөний хайргархаг гадаргатай элсэнцэр хөрсөд *Caragana pygmaea* зонхилно. Мөн *Allium anisopodium* өндөр арвтай ургахаас гадна *Salsola collina*, *Artemisia macrocephala*, *Dracocephalum foetidum*, *Dontostemon integrifolia* зэрэг зүйл ургамал, мөн *Artemisia klementzea*, *A. xanthochroa*, *Iris tenuifolia*, *Bromus irkutensis* зэрэг элссэг зүйл ургамал тохиолдоно.

Харгана-зээргэнэт цөлжүү хээр Хар бор элсэнд довцог элсний орой, араар *Caragana bungei*, *Ephedra sinica* зонхилсон эвшил, *Ephedra przewalskii*, *Eurotia ceratoides* зонхилсон өвөрмөц бүлгэмдэлтэй.

## Усан мандал

Нуурын усан мандал (ургамалгүй усан гадарга).

## Хавсралт 5: Газрын экосистемийн ангилал ба орон зайн загвар

Ландшафтын түвшний байгаль хамгааллын төлөвлөлтийн хамгийн чухал хэсэг нь биологийн олон янз байдлыг төлөөлж чадахуйц уудам амьдрах орчны хэв шинж буюу экосистемийн ангиллын зураг байдаг. Бид судалгааны бус нутгийн хүрээнд экосистемийг зураглахын тулд урьд өмнө газрын зурагт буулгасан болон судалгааны олон бүтээлд тодорхойлсон ургамлын булгэдлийн тархац, зонхилох ургамалшлын хэв шинж, зайнаас тандан судлах мэдээлэл ашиглан бэлтгэсэн газрын гадаргын хэв шинж, өндөршил, ургамлын биомассын газрын зурагтай харьцуулсан орон зайн загвар боловсруулсан юм. Судалгааны үр дүнд бүтээсэн экосистемийн ангиллын зургийг 1) био-газарзүйн муж, 2) ургамшил, өндөршил болон геоморфологид үндэслэсэн газрын экосистемийн хэв шинж, ба 3) газрын гадаргын хэв шинжээр тус тус ялган бэлтгэв. Бид хүрээнд буй орчны ялгаатай байдал болон зонхилох амьдрах орчны төрлүүдийг 600,000 гаруй км<sup>2</sup> талбай бүхий уудам газар нутгийн хэмжээнд алдаа багатай, нэг ижил масштабаар газрын зурагт буулгах бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэж чадахуйц арга зүй, мэдээллийн санг бүрдүүлэн ажилласан. Энэ ажлын хүрээнд бид ландшафтын түвшний байгаль хамгааллын төлөвлөлт, газар зохион байгуулалт, судалгаа ба мониторингид ашиглаж болохуйц, цаашид сайжруулан боловсронгуй болгох боломжтой экосистемийн ангилал боловсруулах орон зайн загварын анхны хувилбарыг дэвшүүллээ. Орон зайн мэдээлэл дээр тулгуурласан ГМС-ийн загвар ашиглах арга нь мэдээллийн эх үүсвэр ба хээрийн судалгааны мэдээлэл шинээр бий болох тутам сайжруулах боломж олгохоос гадна, цаашид орон зайн мэдээлэл цуглуулах судалгаа шинжилгээний ажилд чиглэл өгөх давуу талтай.

Бид АНУ болон Латин Америкийн

экологийн системд нийцүүлэн боловсруулсан экосистемийн ангиллын арга (Comer et al. 2003) дээр тулгуурлан Монгол орны экосистемийг зураглах болон тодорхойлох арга боловсруулан ажилласан юм. Энэ аргыг ландшафтын түвшний байгаль хамгааллын төлөвлөлтөд нэн чухал экосистемийн ангилал хийхэд ашигладаг. Бидний боловсруулсан экосистемийн ангиллын арга нь "экосистемийн үйлчилгээ" болон амьдрах орчны хувьд чухал, тэдгээрийг тэтгэж байдаг экологийн үйл явц, хэв шинжийг төлөөлж чадах, ГМС-ийн байгаа мэдээллийг ашиглан, экосистемийг бус нутгийн хэмжээнд газрын зурагт буулгах боломж олгосон юм. Уг аргачлалын дагуу экосистем нь ижил төстэй физик орчинд тохиолдох, ижил төстэй экологийн үйл явцаас хамаарал бүхий биологийн бүлгэмдлээр тодорхойлогдоно. Экосистемийг био-газарзүйн бус нутаг (жишээ нь: экологийн бус нутаг)-ийн хүрээнд орон зайн тархацын хувьд түгээмэл, уудам өвөрмөц, багавтар өвөрмөц болон зурvas хэлбэрийн хэмээх 4 ялгаатай хэв шинж болгон ангилав. Ой болон хээр зэрэг түгээмэл тархацтай экосистем нь ихэнх тохиолдолд өндөрлөг газрыг даган ялгаатай олон хэв шинж бүхий ургамлын бүлгэмдлийн үргэлжилсэн алаг цоог бүрхэвч үүсгэдэг. Тарамцаг элс, голын татмын намгархаг газар зэрэг өвөрмөц болон зурvas тархацтай экосистем нь шим ба биет (физик) орчны эрс ялгаатай хүчин зүйлүүдээр тодорхойлогдох ба ихэвчлэн түгээмэл тархацтай экосистемээр хүрээлэгдэн оршино. Бидний боловсруулсан экосистемийг ангилах, газрын зурагт буулгах энэ аргачлалыг амьдрах орчны бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлж байдаг хүрээнд буй орчны хэв шинж, үйл явц, олон хэмжээст бүтэц зохион байгуулалтыг газрын зурагт буулгаж, хээрийн судалгаагаар нийцлийг нягтлах боломжтой юм (Comer et al., 2003).

Энэ судалгааг гүйцэтгэхэд Монгол орны өргөн уудам газар нутгийн хувьд харьцангуй таарцтай, жигд масштабтай, ил тод, баримтжуулсан арга зүй болон мэдээллийн эх үүсвэр дээр үндэслэсэн бус нутгийн хэмжээний ургамал болон амьдрах орчны ангиллын зураг шаардлагатай байв. Монгол-Оросын хамтарсан экспедици 1970 оноос хойш өргөн цар хүрээтэй, хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэж, үр дунд хэд хэдэн 1:1,000,000 -с 1:2,000,000 масштабтай улсын болон бус нутгийн түвшний ургамал, экосистемийн зургийг бүтээжээ (e.g. Vostokova and Gunin, 2005; Yunatov et al., 1979). Эдгээр газрын зураг нь орон зайн хувьд жижиг масштабтай хийгдсэн тул амьдрах орчин болон зэрлэг амьтан, хүн, малын чухал ундны эх булаг болох голын татам болон гүний уснаас хамааралтай экосистемийг харьцангуй муу ялгасан байдаг. Сүүлийн жилүүдэд зайнаас тандан судлалын мэдээлэл, загварчлалд чухал дэвшил бий болсноор тоон дүн шинжилгээний арга ашиглан ургамалшил болон ландшафтын ангиллыг орон зайн нарийвчлал сайтай масштабаар зураглах бололцоо бүрдээд байгаа юм. Тухайлбал, Landsat TM хиймэл дагуулын мэдээ (NASA, 2011)-г ашиглан олон спектрын зургийн ангилал хийх, "Ургамлын нормчилсон ялгаврын индекс" (NDVI) (e.g. MODIS 13Q1 - LP DAAC 2013)-ийг ашиглан ургамлын биомассыг орон зайн болон цаг хугацааны ялгаатай хэмжих, "өндрийн тоон загвар" (DEM) (e.g. SRTM; Jarvis et al. 2008, Lehner et al. 2008)-ыг ашиглан өндөршил, газрын гадаргын хэв шинж, гадаргын гидрологийг загварчлах зэргийг дурдаж болно.

Судалгаанд хамрагдсан өргөн уудам газар нутгийн хувьд маш их хэмжээний хээрийн судалгааны суурь мэдээлэл, компьютерийн боловсруулалт, цаг хугацаа шаарддаг тул Landsat хиймэл дагуулын мэдээлэлд суурилсан олон спектрийн зургийн ангиллыг ашиглах боломжгүй байлаа. Тиймээс бид

зонхилох экосистемийн хэв шинжийг энгийн сэдэвчилсэн байдлаар ангилсан ба тэдгээрийн бус нутгийн хүрээнд олдоц бүхий өндөршил, биомасс, газрын гадаргуугын мэдээлэл зэргийг ашиглан газрын зурагт буулгаж, орон зайн загвар боловсруулж ашигласан. Сэдэвчилсэн ангиллыг ДБХС-ийн экосистемийн газрын зураг болон бусад бүтээлд (Chimed-Ochir et al. 2010, Востокова, Гунин 2005, Түвшинтогтох 2014, Бекет 2009, Дашилжиргээн 2009, Zemmerich et al. 2010, Hilbig 1995) тодорхойлсон ургамалшил болон амьдрах орчны ангилал дээр тулгуурлан боловсруулав. Экосистемийн ангиллыг газрын зурагт буулгах орон зайн загварыг боловсруулахад холбогдох судалгааны бүтээл (Бекет 2009, Zemmerich et al. 2010), үндэсний болон бус нутгийн хэмжээний экосистем ба ургамалшлын газрын зураг, орон зайн дүн шинжилгээ (Chimed-Ochir et al. 2010; Востокова, Гунин 2005; Дашилжиргээн 2009, Лхагвасүрэн 2014)-нд тулгуурлан хүрээлэн буй орчны хүчин зүйлүүд, био-физикийн босго утгууд дээр үндэслэн боловсруулсан юм.

### Газрын экосистемийн ангилал

Газрын гадаргын хэв шинж, биофизик орчин, ургамалшлын хэв шинж дээр үндэслэн ялгасан экосистемийн хэв шинжийг био-газарзүйн мужаар хувааж ангилав. Энэ судалгааны үр дунд биогазарзүйн муж, экосистемийн хэв шинж ба газрын гадаргын хэв шинжээр ялгагдах экосистемийн 182 ялгаатай хэв шинжийг ангилан тодорхойлов. Мэдээллийн багцын эх сурвалж болон арга зүйг Хүснэгт 1-с үзнэ үү. Био-газарзүйн муж болон загварчлал ашиглан газрын зурагт буулгасан экосистемийн хэв шинжийг Зураг 1 ба Хүснэгт 2-т тус тус үзүүлэв.


### Үе шат I: Био-газарзүйн муж

Био-газарзүйн муж нь бус нутгийн уур амьсгал ба физик газарзүйн ерөнхий хэв шинж, тэдгээрээс хамааралтай зүйлийн ба генетик олон янз байдлыг илэрхийлдэг.

Судалгааны бүс нутагт тархсан дийлэнх экосистемийн хэв шинжийг био-газарзүйн муж бүрээр тусгайлан ялгах нь хүрээлэн буй орчны хэв шинж, зүйлийн бүрдлийн ялгаатай байдлыг тодорхойлох ач холбогдолтой. Нөгөө талаас судалгааны бүс нутгийн хэмжээнд хамгаалах шаардлагатай газар нутгийг сонгох үйл явцад экосистемийг био-газарзүйн муж тус бүрээр сонгон хамгаалах боломж олгох давуу талтай. Газарзүйн хувьд, ийнхүү давтагдах байдлыг авч үзэх нь цаг уурын гэнэтийн үзэгдэл, өвчин эсвэл

харь зүйл тархах зэрэг хөнөөлөөс болж биологийн олон янз байдал тодорхой нэг газар нутагт устаж болзошгүй нөхцөлөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Бид энэ судалгааны хүрээнд био-газарзүйн мужийг тодорхойлох, газрын зурагт буулгахад Др.Даш (2007)-ийн ДБХС-ийн "Орхигдлын үнэлгээний тайлан" (Chimed-Ochir et al. 2010)-д тусгасны дагуу Хангай болон Хөвсгөлийн бүс хэмээх 2 ландшафт-экологийн дэд бүсэд хуваан ангилав (Зураг 1).

**Зураг 1:** Экосистемийн ангиллыг тодорхойлоход сонгосон биогазарзүйн мужлал нь Др.Даш (2007) болон ДБХС-ийн Орхигдлын үнэлгээгээр (Chimed-Ochir et al. 2010) тодорхойлсон ландшафт-экологийн бүс юм.



## Үе шат II: Газрын экосистем

Экосистем нь ерөнхийдөө шим (ургамал, амьтан) ба биет (хүрээлэн буй физик орчны шинж чанар, үйл явц) бүрэлдэхүүн хэсгээр тодорхойлогддог бөгөөд физик орчны үйл явцаас хамаарч орон зайн, тархацын хэв шинжээр ялгаатай байдаг. Бид байгалийн экосистемийг орон зайн цар хүрээнд үндэслэн хоёр түвшинд ангилж зураглав. Нэгдүгээрт,

ерөнхий хэв шинж болох өндөршил, ургамалшил, газрын гадаргуун ялгаагаар тодорхойлогдох, уудам орон зайд тархдаг сэргүүн бүсийн ой, уулын хээр зэрэг түгээмэл экосистемийг нарийвчлал багатай газрын зурагт буулгасан юм. Хоёрдугаарт, газрын гадарга, гадаргын урсац, хиймэл дагуулын зураг ашиглан харьцангуй нарийвчлалтай тогтоосон ус намгархаг газар, тарамцаг элс зэрэг эрс

ялгаатай өвөрмөц, жижиг хэмжээтэй экосистемийг ангилж, илүү нарийвчлалтай газрын зурагт оруулсан болно. Мэдээллийн эх сурвалж, арга зүйг Хүснэгт 1-т үзүүлэв. Үр дүнг Зураг 2-с үзнэ үү.

Түгээмэл экосистем нь уур амьсгал болон хур тунадасны ерөнхий хэв шинжийг даган өргөн уудам газарт тархана. Үүнд, сэргүүн бүсийн ой, зургаан ялгаатай томоохон хэв шинжийн хээр, цөлжүү хээр болон хээржүү цөл хамрах бөгөөд эдгээр экосистемийг өндөршил, ойн бүрхэвчийн эзлэх хувь хэмжээ болон ургамлын биомасс зэрэг үзүүлэлтийг ашиглан тодорхойлох боломжтой. Эдгээр бүх үзүүлэлтийг зайнаас тандан судлах хиймэл дагуулын мэдээллийн тусламжтайгаар дэлхийн хэмжээнд ялгах, газрын зурагт буулгах боломж бий. Өндрийн тоон загвар (SRTM, Jarvis et al. 2008, Lehner et al. 2008)-ийг ашиглан өндөршлийн мэдээллийг бэлтгэсэн бөгөөд энэ үзүүлэлтийг ашиглан уур амьсгалын ялгаатай бүсүүд болон томоохон ургамалшлын хэв шинжийн тархацыг илэрхийлж болно. Энэ талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг нэгэнт хэвлэгдсэн шинжлэх ухааны бүтээлүүдээс үзнэ үү (Бекет 2009, Zemmerich et al. 2010, Hilbig 1995, Түвшинтогтох 2014). Ойн бүрхэвчийн эзлэх хувь хэмжээ болон ургамлын биомассыг ургамлын нормчилсон ялгаврын индекс (NDVI - MODIS 13Q1, NASA 2014)-ын утга ашиглан тодорхойлон. Ургамлын нормчилсон ялгаврын индекс (NDVI)-ийг ургамал, амьтны экологийн судалгаанд ургамалшлын хэв шинж, бүтээмжийн орон зайн болон цаг хугацааны ялгаатай орших хэв шинжийг тодорхойлоход түлхүү ашигладаг (Pettorelli et al. 2011; Pettorelli et al. 2005; Williamson et al. 2012). Бид Монгол орны болон бус нутгийн хэмжээнд боловсруулсан экосистем ба ургамалшлын газрын зургууд, орон зайн дүн шинжилгээ (Chimed-Ochir et al. 2010, Востокова, Гүнин 2005, Даш 2009, Лхагвасүрэн 2014), судалгааны бүтээлүүд (Бекет 2009, Zemmerich et al. 2010) дээр

үндэслэн өндөршил, ойн бүрхэвч болон ургамлын биомассын босго утгуудыг тогтоож, экосистемийн ангилал хийх орон зайн загвар боловсруулав.

Бид өндрийн тоон загвар (DEM)-с боловсруулсан ус намгархаг газрыг зураглах загвар (Smith et al. 2008) ашиглан, ус намгархаг газрын 4 ялгаатай хэв шинж, Landsat TM-н зураглал (Hansen et al. 2013) ашиглан усан орчин, 1:200000 масштабтай газрын зургаас (U.S.S.R. Military Topographic Map Administration, 1952) уудам газарт тархан орших элстэй газруудыг тоон хэлбэрт буулгах замаар тарамцаг элс зэрэг өвөрмөц экосистемийн хэв шинжийг тус тус ангилж, газрын зурагт буулгалаа. Өндрийн тоон загвар (DEM)-аар боловсруулсан орон зайн загварыг тухайн орчны газрын гадарга, гадаргын урсац (гидрологи)-д үндэслэн ус намгархаг орчныг газрын зурагт буулгахад ашигладаг. Байнгын урсацтай гол, горхи, булаг зэрэг чийглэг газар уг загварыг ашиглан томоохон гол мөрөн, жижиг гол голуудын татмыг газрын зурагт буулгадаг. Харин гандуу хуурай бус нутагт энэ дурдсан загварыг гүний ус газрын гадаргад ойр орших томоохон цайдам хотгор, жижиг сайруудыг газрын зурагт буулгахад ашиглав. Голын татмын экосистем нь ургамлын биомассаар ялгагдах ой, сөөг, нуга ба хайргат зурvas зэрэг экосистемийн дэд хэв шинжид хуваагдана. Түүнчлэн цайдам хотгорын экосистемийг ургамлын биомассаар ялгаж болох өндөр модлог ургамалт, нуга болон хужир марзлаг шал зэрэг дэд хэв шинж болгон ангилсан. Эдгээр экосистемийн хэв шинж тус бүрийн экологи болон ургамлын бүлгэмдлийн талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 2-оос үзнэ үү.

Бид голын татам, ус намгархаг газрыг тодорхойлох ажлыг Монгол орны хэмжээнд хийж гүйцэтгэсэн юм. Энэ ажил нь Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яамны захиалгаар ДБХС-н хийж гүйцэтгэсэн “Усны тухай хууль” (Mongolian Law on Water, 2007)-ийг хэрэгжүүлэх хүрээнд гол мөрний хамгаалалтын бус

тогоох ажлын үндэс суурь болсон гэдгийг дурдах хэрэгтэй. Энэ ажлын талаар ДБХС (WWF Mongolia and TNC Mongolia, 2014)-н гүйцэтгэсэн тайлан, зөвлөмжид дэлгэрэнгүй тайлбарлажээ. Энэ судалгаанд ашигласан орон зайн загварын үр дүнг одоогийн байдлаар шалган засварлаж орон нутгийн газар ашиглалт болон хамгааллын төлөвлөгөөнд тусгахаар ажиллаж байна (WWF Mongolia 2015).

### Үе шат III: Газрын гадаргын хэв шинж

Судалгаанд хамрагдсан бүс нутгийн 90 орчим хувьд түгээмэл экосистемийн хэв шинж, амьдрах орчны сүйтгэл, экологий үйл явц, сукцессийн орчлоор бий болсон өөр хоорондоо ялгаатай, алаг цоог ургамлын бүлгэмдлээс тогоо түгээмэл экосистемийн хэв шинж болох ой, хээрийн хэв шинж болон хээржүү цөл тархана. Эдгээр түгээмэл экосистемийн ургамлын бүлгэмдэл нь их төлөв газрын гадаргын орчны ялгаанаас хамааралтай илэрдэг. Экологи, хүрээлэн буй орчин, генетик олон янз байдлыг дэлгэн үзүүлэх зорилгоор хээрийн экосистемийн ялгаатай хэв шинжийг газрын гадаргын хэв шинжид үндэслэн ангилав. Хөрсний шинж чанар, усны баланс ба бичил уур амьсгалын өөрчлөлтийг төлөөлөх Топографийн нийлмэл индекс (Gessler et al., 1995; Moore et al., 1991) болон налуу, зүг зовхисын хамаарал (Stage, 1976) зэргийг багцалсан ангилал (клuster анализ)-ын аргаар нэгтгэн газрын гадаргын хэв шинжийг ялган тодорхойлж газрын зурагт оруулсан (Зураг 6).

### ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Байгалийн нөөц баялгийн ашиглалт эрчимтэй нэмэгдэж буй өнөө үед ландшафтын түвшний био-газарзүйн мэдээлэл нь байгаль хамгаалал, менежмент болон хөгжлийн нөлөөллийг бууруулах ажлыг чиглүүлэхэд чухал зөвлөмж болдог. Дээр дурдсан экосистемийн ангиллын зураг нь судалгааны мэдээлэл хомс нөхцөлд дэлхийн хэмжээний олдоцтой мэдээллийг

ашиглан экосистемийг уудам бүс нутгийн цар хүрээнд харьцангуй богино хугацаанд тодорхойлж, газрын зурагт буулгах боломжтойг илтгэж байна. Ийм төрлийн орон зайн загварыг боловсруулж, өөрчлөн сайжруулахад харьцангуй богино хугацаа шаардагдах ба ландшафтын түвшний байгаль хамгааллын төлөвлөлт, бүс нутгийн газар ашиглалтын төлөвлөлт, судалгаа ба мониторинг хийхэд ашиглах боломжтой юм.

Энэ загвар нь хүрээлэн буй орчны ялгаатай хэв шинж ба экосистемийн тархац хоорондын хамаарал дээр суурилдаг боловч, хүчин зүйлүүдийн харилцан үйлчлэлийг харгалзан үздэггүй талтай. Ирээдүйд энэ загварыг сайжруулахад Ангиллын регрессийн мод (Classification Regression Tree буюу CART), Кластер дүн шинжилгээ (Cluster Analysis)-ний арга (hierarchical agglomerative clustering, fuzzy C-means clustering) зэрэг аргуудыг ашиглаж болно. Гэвч эдгээр аргуудыг хэрэглэхэд судалгааны бүс нутгийн хэмжээнд хээрийн судалгааны мэдээллүүд шаардлагатай болно.

Экосистем болон ургамалшлын тархацын орон зайн загварыг боловсруулах ажил нь ургамлын ургацын хугацааны ургамлын нормчилсон ялгаврын индекс (NDVI)-ийн 12 жилийн дундаж утга, өндөршил болон газрын гадаргын мэдээллийг ашиглан тогтоосон ус зүй, ургамалшлын хэв шинж болон бүтцийг тодорхойлж болох бусад хүчин зүйлийн мэдээллийг ашиглаж болох юм гэдэг таамаг дээр үндэслэв. Ургамлын нормчилсон ялгаврын индекс (NDVI)-ийг ашиглан ургамалшлыг газрын зурагт буулгах, дүн шинжилгээ хийх олон арга, хэрэгсэл бий. Williamson et al. (2012) нар цаг хугацааны хувьд нэгтгэсэн ургамлын нормчилсон ялгаврын индекс (NDVI)-ийн утга нь сөөгөн бүрхэвчийн орон зайн өөрчлөлтуүд, үүний зэрэгцээ үетэнт хээрийг сөөгт газраас ялгах боломжтойг тогтоосон нь цаашид энэ загварыг улам сайжруулах боломжтойг илтгэж байна.

Экологийн ангилал нь олон удаа давтаж хийх үйл явц юм. Бидний боловсруулсан экосистемийн орон зайн загварыг хээрийн богино хугацааны болон олон жилийн суурин судалгаа, жижиг орон зайн хүрээнд нарийвчлал сайтай ургамалшлын зураг хийх зэрэг нэмэлт мэдээлэл ба

арга зүйг ашиглан баталгаажуулж, хянан сайжруулах нь зүйтэй. Экосистемийн загварын одоогийн үр дүнг уг загварыг цаашид сайжруулах, хээрийн судалгааг төлөвлөх, чиглүүлэхэд ашиглах боломжтой юм.

## Хүснэгт 1: Газрын экосистемийн ангилал: Мэдээллийн эх сурвалж, зураглал хийсэн аргачлал

Экосистемийн хэв шинжийг (i) био-газарзүйн муж, (ii) ургамалшлын бүтэц ба био-физик орчин, (iii) газрын гадаргын хэв шинжээр тус тус ангилсан. Үүний үр дүнд экосистемийн 182 ялгаатай хэв шинжийг ялгасан юм.

### i. Био-газарзүйн муж (WWF National Gap Assessment - Chimed-Ochir et al., 2010) Зураг 1-ийг үзнэ үү.

Хөвсгөл

Хангай

### ii. Экосистемийн хэв шинж. Зураг 2-г үзнэ үү.

**Түгээмэл экосистем** нь уур амьсгал, хур тунадасны ерөнхий хэв шинжээр тодорхойлогдоно. ГМС-н мэдээллийг ургамлын нормчилсон ялгаврын индекс (NDVI, MODIS 13Q1)-ийн угтатай дүйцүүлэн 250м нарийвчлалтай болгон шилжүүлсэн болно.

Ян сарьдаг	Өндөршил: SRTM (Jarvis et al., 2008; Lehner et al., 2008). Өндөрийн хязгаар утгыг экосистем, ургамшлын зураг болон бусад судалгаа, шинжилгээний материал дээр үндэслэн тогтоов (Chimed-Ochir et al., 2010; Vostokova and Gunin, 2005; Dash, 2009).
Уулын тундр	
Тагийн нуга	
Өндөр уулын хээр (Монгол Алтай)	
Уулын хээр	Ургамлын нормчилсон ялгаврын индекс (NDVI): Ургалтын үеийн (4-р сараас 9-р сарын хооронд) 13 жилийн дундаж (2000-2012) (MODIS 13Q1, NASA LP DAAC, 2013). Ургамлын нормчилсон ялгаврын индекс (NDVI)-ийн хязгаарын утгыг ашиглан тогтоосон (Chimed-Ochir et al., 2010; Vostokova and Gunin 2005; Dash 2009).
Сэргүүн бүсийн шигүү ой	
Сэргүүн бүсийн сийрэг ой	
Нугажуу хээр	
Нуга	Oйн бүрхэвч: Landsat TM 2000-2012 (Hansen et al., 2013).
Хээр	
Цөлжүү хээр	
Хээржүү цөл	
Жинхэнэ цөл	

**Өвөрмөц экосистем** нь хөрсний чийгшил, гадаргын урсац, бичил уур амьсгал зэрэг нарийвчлалтай хэв шинжээр тодорхойлогдоно. ГМС-н мэдээллийг өндрийн тоон загвар (DEM, 3 arc-second SRTM)-н адиллаар 78м нарийвчлалтай болгон хувиргасан.

Голын татам, ус намгархаг газар

Татмын ой, шугуй	Өндрийн тоон загвар (DEM)-ээр гаргасан газрын гадаргын загвар (Smith et al., 2008).
Сөөгт татам	Oйн бүрхэвч: Landsat TM 2000-2012 (Hansen et al., 2013).
Татмын нуга	
Ус хөвөөлсөн халцгай газар	Ургамлын нормчилсон ялгаврын индекс (NDVI): Ургалтын үеийн (4-р сараас 9-р сарын хооронд) 13 жилийн дундаж (2000-2012) (MODIS 13Q1, NASA LP DAAC, 2013). Ургамлын нормчилсон ялгаврын индекс (NDVI)-ийн хязгаарын утгыг ашиглан тогтоосон (Chimed-Ochir et al., 2010; Vostokova and Gunin 2005; Dash 2009).
Жижиг гол, горхи, булгийн татам	
Цайдалам: Цөлжүү, гандуу нутагийн Гадаргын урсацын ерөнхий хэв шинжийг дагасан, гүний ус ойр, сайр ба хужир мараалаг хотгор. <b>Цөлийн шигүү ургамалтай газар:</b> Ихэвчлэн баянбүрдийн орчимд байх сухай, бургас, тоорой, жигд, улиас, хайлаас, заг зэрэг зүйлийн мод болон бутлаг ургамал шигүү ургасан газар.	
Цөлийн шигүү ургамалтай газар	Өндрийн тоон загвар (DEM)-ээр гаргасан газрын гадаргын загвар (Smith et al., 2008).
Сөөгт цайдам	Oйн бүрхэвч: Landsat TM 2000-2012 (Hansen et al., 2013).
Шал, шавартай тойром	Ургамлын нормчилсон ялгаврын индекс (NDVI): Ургалтын үеийн (4-р сараас 9-р сарын хооронд) 13 жилийн дундаж (2000-2012) (MODIS 13Q1, NASA LP DAAC, 2013). Ургамлын нормчилсон ялгаврын индекс (NDVI)-ийн хязгаарын утгыг ашиглан тогтоосон (Chimed-Ochir et al., 2010; Vostokova and Gunin 2005; Dash 2009).
Сайр (Их нууруудын хөндий)	
Тарамцаг элс	1:200,000 масштабтай байрзүйн зургаас тоон хэлбэрт хөрвүүлсэн.
Усны мандал	Landsat TM 2000-2012 (Hansen et al., 2013).

(Үргэлжлэл дараагийн хуудсанд)

**Хүснэгт 1: Газрын экосистемийн ангилал:** Мэдээллийн эх сурвалж, зураглал хийсэн аргачлал (үргэлжлэл)

- iii. **Газрын гадаргын хэв шинж** нь хөрсний чийгшил, бичил уур амьсгалын хэв шинжээр тодорхойлогдох ургамлын бүлгэмдлийн ялгааг нарийвчлалтай тогтоох боломж олгоно. Эдгээрийг түгээмэл тархацтай экосистемийн хэв шинжийг дотор нь ялгахад ашигласан. Зураг 3-г үзнэ үү.

Эгц ар хажуу	78 метрийн ялгах чадвартай өндрийн тоон загвараас гаргаж авсан топографийн З загвараас кластер анализ ашиглан зураглал хийсэн:
Эгц өвөр энгэр	Нийлмэл топографийн индекс (Gessler et al., 1995; Moore et al., 1991)
Ар хажуу	
Өвөр энгэр	
Тэгш өндөрлөг	Налуу, зүг зовхисын хамаарал (Stage 1976)
Хотгор	
Голдрил	


**Хүснэгт 2: Газрын экосистемийн ангилал:** Судалгаанд хамрагдсан био-газарзүйн мужаар тохиолдох ялгаатай экосистемийн хэв шинжийн тархац.

Экосистемийн хэв шинж	Нийт судалгааны бүс нутаг (4 экологийн бүс)		Монгол Алтайн нуруу		Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий		Хангай		Хөвсгөл	
	км <sup>2</sup>	%	км <sup>2</sup>	%	км <sup>2</sup>	%	км <sup>2</sup>	%	км <sup>2</sup>	%
<b>Түгээмэл экосистемийн хэв шинж</b>										
Жинхэнэ цөл	4,108	1			4,108	2				
Хээржүү цөл	43,450	7	1,026	1	40,833	20	1,591	1		
Цөлжүү хээр	77,965	13	11,451	16	62,289	31	4,225	2		
Хээр	113,237	18	7,001	10	34,006	17	67,602	25	4,628	6
Нуга	10,250	2	104	0.1	1,045	1	7,959	3	1,142	1
Сэргүүн бүсийн ой										
Шигүү ой	24,315	4	293	0.4	4	0.00	13,345	5	10,673	14
Сийрэг ой	35,529	6	633	1	47	0.02	19,814	7	15,035	20
Нугажуу хээр	56,379	9	1,037	1			42,777	16	12,566	16
Уулын хээр	120,767	19	16,925	24	10,408	5	76,355	28	17,079	22
Өндөр уулын хээр	18,652	3	18,652	26						
Тагийн нуга	42,573	7	3,962	6	9,846	5	21,216	8	7,548	10
Уулын тундр	7,444	1	2,823	4	1,662	1	1,140	0.4	1,818	2
Ян сарьдаг	2,311	0.4	1,851	3	331	0.2	13	0.0	117	0.2
<b>Өвөрмөц экосистемийн хэв шинж</b>										
Голын татам, ус намгархаг газар										
Татмын ой	1,644	0.3	196	0.3	490	0.2	426	0.2	532	1
Сөөгт татам	6,140	1	693	1	1,769	1	2,768	1	910	1
Татмын нуга	10,294	2	826	1	2,791	1	5,916	2	762	1
Ус хөвөөлсөн халцгай газар	8,509	1	1,207	2	5,844	3	1,441	1	17	0.02
Жижиг гол, горхи, булгийн татам	4,465	1	771	1			2,934	1	760	1
Цайдам хотгор										
Цөлийн шигүү ургамалтай газар	167	0.03	8	0.01	159	0.1				
Сөөг, дэрс, шагшуургат чийглэг нуга	469	0.1			469	0.2				
Тойром, шал	1,020	0.2			1,020	1				
Сайр	2,607	0.4			2,607	1				
Тарамцаг элс	17,135	3	264	0.4	15,346	8	1,525	1		
Усан мандал	12,904	2	1,163	2	7,657	4	1,061	0.4	3,022	4
Нийт талбай	622,333	100	70,886	100	202,729	100	272,109	100	76,609	100
Судалгаанд хамрагдсан талбайд эзлэх хувь	100 %		11 %		33 %		44 %		12 %	


**Зураг 2:** Экосистемийн ангилал



Үргэлжлэл



**Зураг 3:** Газрын гадаргын хэв шинжийг өндрийн тоон загвараас боловсруулсан топографийн 2 индексэд үндэслэн боловсруулсан. Судалгааны бус нутгийн хүрээнд 7 ялгаатай гадаргын хэв шинжийг ялгав. Бид энэ ангиллыг 1) түгээмэл экосистемийн төрлийг ялгах болон 2) амьтны тархацын загвар боловсруулахад ашигласан болно.



## НОМЗҮЙ

- Beket U., 2009. The Vegetation of Mongolian Altai. Mongolian Academy of Sciences. Ulaanbaatar.
- Chimed-Ochir B, Hertzman T, Batsaikhan N, Batbold D, Sanjmyatav D, Onon Yo and Munkhchuluun B (2010) Filling the GAPs to protect the biodiversity of Mongolia. World Wildlife Fund Mongolia Program. Admon. Ulaanbaatar.
- Comer, P., D. Faber-Langendoen, R. Evans, S. Gawler, C. Josse, G. Kittel, S. Menard, M. Pyne, M. Reid, K. Schulz, K. Snow, and J. Teague. (2003) Ecological Systems of the United States: A Working Classification of U.S. Terrestrial Systems. NatureServe, Arlington, Virginia
- Dash D. (2007) Examination of the Ecoregion map selection for conducting Gap analysis on Biodiversity Conservation and/or Protection. Mongolian Academy of Sciences, Institute of Geoecology. Ulaanbaatar.
- Dash (2009) Map of Great Lake Depression Landscape. Institute of Geo-ecology. Ulaanbaatar.
- Gessler, P. E., Moore, I. D., McKenzie, N. J., & Ryan, P. J. (1995). Soil-landscape modelling and spatial prediction of soil attributes. International Journal of Geographical Information Systems, 9(4), 421-432.
- Hansen M. C., P. V. Potapov, R. Moore, M. Hancher, S. A. Turubanova, A. Tyukavina, D. Thau, S. V. Stehman, S. J. Goetz, T. R. Loveland, A. Kommareddy, A. Egorov, L. Chini, C. O. Justice, and J. R. G. Townshend. High-Resolution Global Maps of 21st-Century Forest Cover Change. Science 15 November 2013: 342 (6160), 850-853. [DOI:10.1126/science.1244693]
- Heiner M, Batsaikhan N, Galbadrakh D, Bayarjargal Y, Zumberelmaa D, Ariungerel D, Evans J, von Werden H and Kiesecker J (2015) Towards a National GIS Model to Map Terrestrial Ecosystems in Mongolia: A Pilot Study in the Gobi Desert Region. In (Fernandez-Gimenez ME, Batkhishig B, Fassnacht SR, Wilson D, eds.) Proceedings of Building Resilience of Mongolian Rangelands: A Trans-disciplinary Research Conference, Ulaanbaatar Mongolia, June 9-10, 2015, pp 24-34. ISBN 978-99962-971-7-5. Available online: <http://warnercnr.colostate.edu/annual-meetings/2-uncategorised/1158-mor2-conference>.
- Hilbig W (1995) The Vegetation in Mongolia, SPB Academic Publishing, 13–32.
- Jarvis, A., H.I. Reuter, A. Nelson, E. Guevara, (2008) Hole-filled SRTM for the globe Version 4, available from the CGIAR-CSI SRTM 90m Database (<http://srtm.cgiar.org>).
- Lhagvasure Ch (2014) Altai Mountains vegetation survey and map. Khovd University. Khovd.
- Lehner B, Verdin K, and Jarvis A (2008) New global hydrography derived from spaceborne elevation data. Eos, Transactions, AGU 89:93-94.
- Land Processes Distributed Active Archive Center (LP DAAC), 2013, Vegetation Indices 16-Day L3 Global 250m. MOD13Q1. NASA EOSDIS Land Processes DAAC, USGS Earth Resources Observation and Science (EROS) Center, Sioux Falls, South Dakota (<https://lpdaac.usgs.gov>), accessed January 1, 2013, at [https://lpdaac.usgs.gov/dataset\\_discovery/modis/modis\\_products\\_table/mod13q1](https://lpdaac.usgs.gov/dataset_discovery/modis/modis_products_table/mod13q1).
- Mongolian Law on Water (2007), Amendment 2007-5-17.
- Moore ID, Grayson RB and Ladson AR (1991) Digital Terrain Modelling: A Review of Hydrological, Geomorphological, and Biological Applications. Hydrological Processes, 5:3-30.
- NASA Landsat Program (2011) Landsat TM. USGS/Earth Resources Observation and



- Science (EROS) Center, Sioux Falls, South Dakota.
- Pettorelli N, Ryan S, Mueller T, Bunnefeld N, Jedrzejewska B, Lima M, Kausrud K. (2011) The Normalized Difference Vegetation Index (NDVI): unforeseen successes in animal ecology. *Climate Research*. 46(1):15-27.
- Pettorelli N, Vik JO, Mysterud A, Gaillard JM, Tucker CJ, Stenseth NC. (2005) Using the satellite-derived NDVI to assess ecological responses to environmental change. *Trends in ecology & evolution*. 20(9):503-10.
- Richards, J. A. 1986. *Remote Sensing Digital Image Analysis: An Introduction*. Berlin: Springer-Verlag.
- Smith MP, Schiff R, Olivero A, MacBroom JG. (2008) The active river area: A conservation framework for protecting rivers and streams. *The Nature Conservancy*, Boston, MA.
- Stage AR (1976) An Expression of the Effects of Aspect, Slope, and Habitat Type on Tree Growth. *Forest Science* Vol 22, No 3, 457-460.
- Tuvshintogtokh I. (2013) The steppe vegetation of Mongolia. UB.: Bembi san, 2014. 610 p. ISBN: 978-99962-3-239-8
- U.S.S.R. Military Topographic Map Administration (1952) Topographic map, map scale 1:200,000. Ulaanbaatar.
- von Wehrden H, Wesche K and Miehe G (2009) Plant communities of the southern Mongolian Gobi. *Phytocoenologia*, 39 (3), 331-376.
- Vostokova EA and Gunin PD (2005) Ecosystems of Mongolia. Russian Academy of Sciences, Mongolian Academy of Sciences, Moscow. GIS data available online at <http://geodata.mne-ngic.mn:8080/geonetwork/srv/en/main.home>.
- Wesche K, Miehe S and Miehe G (2005) Plant communities of the Gobi Gurvan Sayhan National Park (South Gobi Aymak, Mongolia). *Candollea* 60:149–205.
- Williamson JC, Bestelmeyer BT, Peters DP. (2012) Spatiotemporal patterns of production can be used to detect state change across an arid landscape. *Ecosystems*. 15(1):34-47.
- WWF Mongolia and TNC Mongolia, 2014. Mapping report for riparian and wetland areas of water bodies in Mongolia (a part of tender work, # MEGDT/2014/K7).
- Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн Монгол дахь Хөтөлбөрийн Газар ба Де Нэйчэ Консерванси Монгол. 2014. Усны сан бүхий газрын байгалийн хилийг зурагласан ажлын тайлан (зөвлөх үйлчилгээний ажлын хэсгийн тайлан, № БОНХЯ/2014/K7)
- WWF Mongolia, 2015. Final revision report after validation and mapping for riparian and wetland areas of rivers and lakes in basins of Kherlen River, Onon River, Ulz River and Khar lake-Khovd River, Khyargas lake-Zavkhan River, Uvs lake-Tes River, Khuisiin Gobi-Tsetseg Lake.
- Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн Монгол дахь Хөтөлбөрийн Газар. 2015. Гол, нуурын эрэг орчмын ус намгархаг газар, татмын байгалийн хилийг зурагласан үр дүнг баталгаажуулж, засварласан ажлын тайлан (Сав газар: Хэрлэн гол, Онон гол, Улз гол, Хар нуур-Ховд гол, Хяргас нуур-Завхан гол, Увс нуур-Тэсийн гол, Хүйсийн.govь-Цэцэг нуур).
- Yunatov AA, Dashnima B, Gerbikh AA. (1979) *Vegetation map of the Mongolian People's Republic*. Naukia, Moscow.
- Zemrich A, Hilbig W and Oyuunchimeg D (2010) Plant communities along an elevation gradient under special consideration of grazing in Western Mongolia. *Phytocoenologia*, 40(2-3), 91-115.